

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-31
1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар дүгнэлт	6-9
2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	9-31

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
09 дүгээр сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 53 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Г.Дамдинням, Б.Пүрэвдорж, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Б.Тулга, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ж.Баярмаа, Б.Дэлгэрсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Д.Ганбат.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар дүгнэлтийг 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	6
Бүгд:	15

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, С.Уянга нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: 1.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой бүрэн эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь ... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	5
Бүгд:	15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч ... мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхэлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8 дахь заалтын “... үр шимийг нь хүртэх эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн

2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, мөн зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Д.Мөнхзориг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн ерөнхий нягтлан бодлогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, мөн хорооны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга Б.Бадамсэржид, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, аудитын менежер Д.Цэгмиддорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер С.Нацагдорж, Нийцлийн аудитын газрын аудитын менежер Н.Анхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Ууганбаатар, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Анар, мөн банкны Санхүүгийн зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Хуулийн газрын захирал М.Үнэнбат, Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал Б.Цэнд-Аюуш, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга Г.Аззаяа, мөн газрын Тамгын хэлтсийн ажилтан М.Маралмаа, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, ахлах шинжээч Н.Уранцэцэг, Д.Отгонжаргал, Г.Үлэмждэлгэр, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мэргэжилтэн Р.Хангал, О.Гантулга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр, ахлах шинжээч Г.Базаргүр, Б.Хатантуул, Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга О.Азхүү, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах офицер Б.Оргилболд, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга М.Ралдийжамц, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, мөн газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, мөн газрын Тамгын газрын дарга Л.Нямдаваа, Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Н.Ганбаяр, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Н.Алтансүх, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын дарга С.Ням-Эрдэнэ, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонгоо, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Н.Жамъянхүү, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн

дарга Т.Ганзориг, мөн төвийн Санхүү, ар талын тасгийн дарга Н.Уянга, Дотоод хэргийн их сургуулийн дэд захирал Э.Сэргэлэнбаатар, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Гантулга, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дэд захирал Д.Баярсайхан, мөн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны дарга М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төсвийн дарга Л.Уянга, мөн төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, С.Уянга нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар уг хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 11

Бүгд: 15

26.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, О.Алтангэрэл, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга Г.Аззаяа, мөн газрын Тамгын хэлтсийн ажилтан М.Маралмаа, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 34 минут үргэлжилж, ирвэл зохих 28 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 53 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2026 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Ирц танилцуулах уу? Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Энхбаярын Батшугар гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Лхагвын Мөнхбаатар, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Ганзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн нар хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал хэлэлцэнэ. 1-д Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгал /ЭМД/-ын сангийн 2026 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг ЗГ өргөн мэдүүлсэн. Үүний хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ. 2-т Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ийн 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар дүгнэлт, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай гэсэн ийм 2 асуудлыг хэлэлцэнэ. Горимын санал. Отгонбаяр гишүүн горимын санал гаргая. Отгонбаяр гишүүний микрофоныг өгөөрэй.

У.Отгонбаяр: Байнгын хорооны хэлэлцэх асуудлын дараалалд дарааллыг өөрчлөх тийм горимын санал гаргаж байна. Яагаад гэвэл цэцийн дүгнэлтийг түрүүлж хэлэлцээд санал хураалт байгаа учраас Цэцийн дүгнэлтийг эхэнд нь тавих ийм горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Отгонбаяр гишүүн горимын санал гаргалаа. Дэгийн дагуу санал хураалт явуулъя, санал хураалтдаа бэлдье гишүүдээ. Улсын Их Хурал /УИХ/-ын гишүүн Отгонбаярын саналаар дараалалд өөрчлөлт оруулж, ҮХЦ-ийн дүгнэлтийг эхэнд нь хэлэлцье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 60 хувь нь дэмжиж, уг санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар дүгнэлт

2 дахь асуудал Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар дүгнэлтийг хэлэлцье. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар

зүйлийн 15.2 дахь хэсэгт хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай ҮХЦ-ийн 2026 оны 05 дугаар дүгнэлтийг эрхэм гишүүдэд та бүгдэд тараасан байгаа. Энэ ҮХЦ-ийн 05 дугаар дүгнэлттэй холбогдуулан УИХ-аас итгэмжилсэн төлөөлөгчөөр Сайнзориг гишүүн томилогдон ажилласан. Ингээд Пүрэвжавын Сайнзориг гишүүн товчхон танилцуулга хийх үү та, түүний дараа асуудлаа хэлэлцээд явъя. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. УИХ-ын даргын захирамжаар УИХ-аас итгэмжилсэн төлөөлөгчөөр томилогдож зохиогчийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа эсэх маргаан дээр ажиллалаа. Тэгээд нэр бүхий иргэдээс Зохиогчийн эрхийн тухай хуулийн дээрх заалт буюу хамтын бүтээл туурвисан зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг өв залгамжлал сүүлийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ гэж заасан нь Үндсэн хуулийн 3 заалтыг, 4 заалтыг зөрчиж байна гэдэг асуудлаар мэдээлэл ирүүлж, үүн дээр ҮХЦ-ээс маргаан үүсгэсэн байгаа.

Нэр бүхий иргэдээс мэдээлэл ирүүлэхдээ гаргасан үндэслэлүүдийг товчхон та бүхэндээ хэлье. Үндэслэлийн гол агуулга өвлүүлэгчид байсан хэмжээний оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн эд хөрөнгийн эрхийн өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцуулах, эргээд сүүлчийн зохиогч нас барснаар өв залгамжлал үүсэх тухай маргаан бий болох, хамтын бүтээл туурвисан зохиогчид өвлөх эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх, бусад зохиогчдоо онцгой эрх эзэмших хууль ёсны өвлөгчийн зөвшөөрлөөр тухайн бүтээлийг хуулбарлах, түрээслэх зэрэг маш олон ийм оюуны өмчтэй холбоотойгоор ийм маргаанууд сүүлийн үед гарах нь ихсэх боллоо гэдэг зүйлийг нэр бүхий иргэдээс ирсэн.

Өөрөөр хэлбэл, зохиогч амьдралынхаа бүхий л цаг хугацааны туршид судалсан судалгаа, хуримтлуулсан туршлага, ур чадварт тулгуурласан бүтээсэн энэ бүтээлдээ нэр оруулсан зарим хүмүүс нь зохиогчийг нас барсны дараа хууль ёсны өвлөгчийн эд хөрөнгийн эрхийг бүхэлд нь эзэмшиж, бүтээлийн халдашгүй байдалд нь халдаж, түүний утга агуулгын илэрхийллийг өөрчлөн гуйвуулж хэвлүүлэх, англи хэл рүү орчуулж зарим бүх нэр бүхий орнуудын бүр номын санд хандивлах гэх зэрэг ийм байдлуудаар ингээд маш олон зөрчлүүд гарч байгаа учраас энэ Үндсэн хуульд заасан хүний өмчтэй байх, өмчийг шударгаар олж авах, өмчийнхөө үр шимийг хүртэх, энэ өв залгамжлах эрхийг зөрчиж байгаа байж болзошгүй байна гэдэг зүйл яригдсан. Уг асуудал Монгол Улсын энэ эрх зүйн тогтолцоонд уламжлалт байдлаар явж ирсэн. 1993, 2006 оны хуулиудад байж байгаа зохицуулалт байгаа.

Оюуны өмчийн асуудал сүүлийн жилүүдэд эдийн засгийн эргэлтэд орох асуудал нэлээн нарийвчлалтай болж байгаа учраас үүнээс үүсэх маргаанууд нэлээн бидний харж чадахгүй гэх үү ерөнхийдөө төсөөлөөгүй байдлуудаар ингэж гарч байгаа учраас энэ зохицуулалтыг тодорхой түвшинд сайжруулах шаардлагатай юм байна гэдэг байдлаар мэдээллийг өгсөн. Мэдээж энэ хууль тогтоогч энэ зохицуулалтыг ямар агуулгаар олон улсын гэрээ конвенцын заалтыг яаж агуулгыг ойлгож хийсэн бэ гэдэг тайлбарыг өгөхийн зэрэгцээгээр ер нь хууль тогтоомжийг сайжруулах шаардлага байгаа гэдгийг хууль тогтоогчийн зүгээс хэллээ. Ингээд ҮХЦ-ээс дүгнэлт гарсан. Мөн Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хамтын бүтээл туурвисан зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийн өв

залгамж сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Төр нь өмчлөлийн эрхийг хууль дээр хамгаална, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн иргэний туурвисан оюуны зүйл зохиогчийн өмч мөн, 16 дугаар зүйлийн 3 дахь заалтын хөрөнгийг шударгаар олж авах, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй, мөн зүйлийн 8 дахь заалтын үр шимийг нь хүртэх эрхтэй гэсэнд нийцээгүй байна гэдэг байдлаар Цэц дүгнэлтээ гаргаж дээрх заалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу түдгэлзүүлсэн байна.

Л.Мөнхбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа. ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулан итгэмжилсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье. Байхгүй байна. ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулан санал хураалтаа явуулъя. Сая Сайнзориг гишүүн ч тодорхой тайлбарлалаа, ҮХЦ нэгэнт уг хуулийн холбогдох зүйл заалтууд Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа учраас уг зүйлүүдийг нь хүлээн авч байгаад, холбогдох өөрчлөлтүүдийг хийгээд явах нь зүйтэй юм гэж үзэж байгаа. Тийм учраас энэ санал хураалтуудыг явуулъя. Гишүүд анхаараарай, санал хураалт 4 санал хураалт байгаа. Үүнийгээ уншиж танилцуулъя, саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

1.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой бүрэн эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн Төр нь өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдье. Сайнзориг гишүүнийх, нөгөө арга байхгүй. Сайнзориг гишүүнийх болсон уу? Санал хураалтаа явуулъя, саналын томьёоллыг та бүхэнд уншиж танилцуулсан. Санал хураалт. Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

2 дахь санал хураалтыг явуулъя. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхэлнэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч мөн гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд, энэ чинь шууд явчихна. Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжлээ.

3.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхэлнэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн гурав дахь заалтын хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

4.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хамтын бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 8 дахь заалтын үр шимийг нь хүртэх эрхтэй гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Санал хураалтад оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн Сайнзориг уншиж танилцуулъя. Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

15.06 цаг

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

2 дахь асуудалдаа оръё. Монгол Улсын, ажлын хэсгийн хүмүүсээ оруулаарай. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсэг ороод суугаарай. Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулна. Зарим нь наашаагаа сууж болно. Жаахан наашаагаа ахиад суучхаж болно шүү. Ажлын хэсгийнхэн суудлаа эзэлсэн үү? Хуралдаанаа үргэлжлүүлъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ШЕЗ-ийн дарга Золзаяа, босоод байгаарай, ШЕЗ-ийн гишүүн Энхбаатар, ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Мөнхзориг, эдгээр хүмүүс байгаа юу ШЕЗ-хөн? ШЕЗ-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Наранбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч Эрдэнэцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Энхтөр, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны даргын түр орлон гүйцэтгэгч Мөнх-Алдар, Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч Ариунжаргал, ХЭҮК-ын дарга Сүнжид, ХЭҮК-ын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Бадамсэрээжид, УЕПГ-аас УЕП-ын туслах прокурор Хэрэг эрхлэх газрын дарга Чулуунбат, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга эрхэлсэн комиссар Аззаяа, АТГ-ын Тамгын хэлтсийн ажилтан Маралмаа, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга Очирсүрэн, ХЗДХЯ-наас ХЗДХ-ийн дэд сайд Мөнх-Эрдэнэ, ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба, ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбаяр, ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Хатантуул, ЦЕГ-ын тэргүүн дэд дарга, бригадын генерал Батбаатар, ирсэн үү, цагдаагаас хүн байгаа юм уу? Холбогдох хүмүүсээ байлцуулаарай. ЦЕГ-ын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа Батчулуун, ЦЕГ-ын Санхүү, ар талын албаны Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ралдийжамц, цагдаагаас бусад хүмүүс чинь хаачсан бэ, байгаа юу. ХХЕГ-ын Ар тал, зэвсэглэл, инженер, техникийн асуудал эрхэлсэн дэд дарга, хурандаа Азхүү, ХХЕГ-ын Санхүү,

хөрөнгө оруулалтын газрын тайлан нэгтгэлийн ахлах офицер, дэд хурандаа Оргилболд, ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга хурандаа Өнөртуяа, ШШГЕГ-ын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хошууч Энх-Од, УБЕГ-ын дарга Давааням, УБЕГ-ын Тамгын газрын дарга Нямдаваа, УБЕГ-ын Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ганбаяр, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа Алтансүх, ГИХГ-ын Иргэний харьяатын газрын дарга Ням-Эрдэнэ, ГИХГ-ын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Солонгоо, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Жамъянхүү, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Уранчимэг, АЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нямгэрэл, АЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лхамсүрэн, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, цагдаагийн хурандаа Ганзориг, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Захиргаа удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга, цагдаагийн хошууч Уянга, Дотоод хэргийн их сургуулийн дэд захирал бөгөөд сургалтын газрын захирал, цагдаагийн хурандаа Сэргэлэнбаатар, Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Гантулга, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, дэд хурандаа Баярсайхан, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны дарга, ахмад Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч Болор-Эрдэнэ, ажлын хэсэгт оролцож байгаа албан тушаалтнуудыг мөн танилцуулъя. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Анар, Монголбанкны Хуулийн газрын захирал Үнэнбат, Монголбанкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал Мөнхбаяр, Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал Цэнд-Аюуш, Чингис хаан Баялгийн сан нэгдлээс оролцож байгаа албан тушаалтнууд байна. Уг нэгдлийн Стратеги, бизнес хөгжлийн газрын дарга Мэндбаяр, энэ хүмүүс нь байна уу? Санхүүгийн бодлогын газрын дарга Зоригтбат нар оролцох ёстой, энэ хүмүүсээ байлцуулаарай. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ, Сангийн яамнаас оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сангийн сайдын зөвлөх Хүрэлбаатарын Ганцогт, Сангийн яамны ТНБД Санжаадорж, Нийгмийн бодлогын байнгын хороон дээр эд нар давхцаж байгаа юу, хэзээ орж ирэх вэ? Одоо хүмүүс нь байна уу энд, бусад хүмүүс нь? Сангийн сайд ирсэн байгаа, Сангийн сайд байна. Холбогдох албан тушаалтнууд ороод ирэхээр нь дараа нь танилцуулъя. Үндэсний аудитын газраас орж байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Даваасамбуугийн Баярсайхан, Гүйцэтгэх аудитын газрын захирал Дэлгэрийн Энхболд, Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер Довчинсүрэнгийн Цэгмиддорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Сүхбаатарын Нацагдорж, Нийслэлийн аудитын газрын аудитын менежер Нямдаваагийн Анхбаяр нар оролцож байна.

Байнгын хорооны гишүүдэд холбогдох материалууд тараагдаж танилцуулагдсан байгаа. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно гэж заасан. Уг заалтын дагуу асуулт

асууя. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Баярбаатар гишүүнээр, Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Дараалалд оруулсан уу. Асуултаа асууя, Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би нэг цөөхөн хэдхэн юм асууя гэж бодож байна. Ер нь энэ татварын хууль дээр уг нь татвар төлөгчдөд нэг уян хатан хандаж, татварыг урьдчилан төлөх боломж нэг талдаа олгоод байгаа боловч, жишээ нь 26 онд төлөгдөх ёстой татварыг 25 ондоо аваад зарцуулаад энэ 26 он дээрээ төсвийн орлого жишээ нь дутах ч гэдэг юм уу ийм зүйлүүд гараад байх шиг байна. Би тоог нь буруу хэлбэл зөвтгөөрэй, 1.2 их наяд төгрөгийн татварыг урьдчилаад аваад ингээд хэрэглэчихсэн юм байна. Тэгэхээр энэ асуудал дээрээ Сангийн яам ямар байр суурьтай байгаа юм бэ? Бодлогын хувьд үүнийгээ өөрчлөхгүй юм уу? Энэ үндсэндээ УИХ, парламентын бүрэн эрхэд халдах гэдэг юм уу ийм зохицуулалт болчихсон юм биш биз дээ? Ингээд уг нь яах вэ татвар төлөгчдөдөө уян хатан хандъя гэж байгаа боловч нөгөө талдаа энэ нэг төсвийн хууль дээр тохируулга зохицуулалт нь ийм нарийвчлаагүй гэж үзэж болохоор юм байна. Ийм байдлаар явахаар энэ асуудал дээрээ ер нь ямар байр суурьтай байна? Энэ дээр аудитын байгууллага, төрийн аудитын байгууллага ямар байр суурьтай байгаа юм, үүнийг нэг тодруулаач?

2 дугаарт, энэ нэг зүйл байна. Цалин тэтгэврийг нэмэх энэ асуудал дээр зарчмын хувьд дэмжиж байна. Тэгэхдээ төсвийн тодотголоор энэ ТҮ-ийнх нэмэгдэх гэж байгаа гэдэг мессеж явж байгаа боловч энэ ТҮ дотроо ТҮШҮ гэж ангилал гарчихсан юм байна. Төрийн үйлчилгээний шинжлэх ухааны ажилтан, энэ хүмүүсийн нэмэгдлүүд нь орхигдчихсон гэдэг зүйл ингээд яригдаж байна. Дээрээс нь ТҮМ гэдэг ангилал орхигдчихсон байна. Үүнд нь нөгөө нягтлан бодох бүртгэлүүд нь байдаг юм байна. Энэ төрийн албыг нэг цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ ер нь ялгаварлахгүйгээр нэг жигдхэн нэмэх зарчмын асуудлыг нэг сууриар нь яримаар байна. Энэ асуудлыг ярихаар нэгдсэн нэг хууль гаргаад шийдэх гэж байгаа гээд байгаа байхгүй юу. Нэг хуулиар зохицуулснаараа асуудал шийдэгдэхгүй шүү. Энэ яаж зарчим барих вэ дээр л байгаа. Яг үнэндээ гэхэд энэ төрийн албан хаагчийн цалин чинь УИХ-ын Тамгын газар цалингаа замбараагүй нэмээд л, Хэрэг эрхлэх газар, бусад энэ хэрэг эрхлэх тамгын газрууд уралдаж нэмээд л, хууль сахиулах албан дээр Тагнуул, АТГ нэмээд л, араас нь чирэгдээд л гүйцнэ шүү дээ бүгд. Тэгэхээр ийм нөгөө зарчим буюу зарчим баригдаж байна уу гэдэг дээр л байгаа юм. Тэгэхээр энэ хууль зүйн салбарын цалин хөлсний бодлого, энэ асуудал дээр ер нь цаашдаа ямар байр суурьтай, ямар зарчим барих гэж байгаа юм бэ? Энэ төрийн албан хаагчдын энэ цалингийн нэмэгдлүүд жигдхэн байж болохгүй юм уу, зарчмаараа байж болохгүй юм уу? Энэ дээрх албан хаагчид хасагдчихсан уу? Энэ төсвийн тодотголоор нэмэгдэх юм уу, үгүй юү, үүнийг нэг хариулж өгөөч.

2 дугаарт, энэ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудал байгаа. Энэ өвөл болно, нийслэлээс хүн алга, бензин шатахууны үнэ нэмэгдчихлээ, нийтийн тээврийн хүртээмж чинь муудаад ирнэ. Үүнийг дагаад хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчилд хохирогч болох нөхцөл байдлууд чинь эрс нэмэгдэнэ. Нийтийн тээврүүд чинь зогсчих вий дээ ид өвлийн хүйтнээр, энэ дээр ер нь энэ төсвийн тодотголоор орон нутаг руугаа ямар зарчим барьж чиглэлээ өгсөн юм, тодотголын дараа угаасаа нийслэл, дүүрэг гээд хийгээд явна шат шатдаа, тэгэхдээ үүнийг эртнээс анхаараарай. Тэгэхгүй ингээд яг ид өвлийн үеэр зогсоно. Үүнийгээ дагаад гэмт хэрэг, зөрчил их гардаг, дандаа бага насны хүүхдүүд энэ хохиролд хохирогч болоод

явах ийм нөхцөлүүд байдаг юм шүү. Тэгэхээр энэ дээр яг нэг тодорхой хэмжээний хариулчих газар байна уу гэдэг нэг юм байна.

2 дугаарт, шүүхийн барилга байгууламжтай холбоотой асуудлууд ер нь энэ тодотголоор яах вэ ярих биш, би зүгээр нэг зарчмын юм асуучихъя. Ирэх оны төсөв дээр ч гэсэн ингээд харахаар дутуу л байна лээ. Сангийн яамнаас үүнийг нэг удаадаа нэг бүрэн шийдэх ийм асуудлыг ер нь ямар байр суурьтай байна вэ? Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр шүүх эрх мэдлийн барилга байгууламжийг нэг удаадаа нэг шийдэх ганцхан заалт оруулаад, үүнийгээ улсын төсвөөс нэг ачааллыг нь нэг тэнцвэржүүлээд бага багаар төлөөд явчихвал яадаг юм. Тэгээд ерөөсөө ингээд л ганц 2 барилга гээд л ингээд явдаг. Эцсийн дүндээ шүүхийн шүүгч нар суух гээд байгаа биш, иргэд үйлчлүүлэх гээд байгаа байхгүй юу. Бараг бие бие дээрээ хүрэлцэх шахуу ийм орчинд мэтгэлцэнэ гэж байхгүй. Бараг бие биеийнхээ өөдөөс хараад.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Та хариултаа авсны дараа тодруулж болно. Эхний асуултад Магнайсүрэн дарга хариулъя, дараа нь Сангийн яам хариултаа бэлдэж байгаарай. Тэр 3 номерын микрофон дээр суучих, дараа нь Сангийн яам бэлдэж байгаад хариулаарай, түүний дараа Хууль зүйн яамныхан асуултад хариулна шүү. 3 номерын микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Бид 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг сая энэ хаврын чуулганаар 7 дугаар сард хэлэлцэж баталсан. Энэ хүрээнд бид энэ 2025 оны татварын орлогыг хэт өөдрөгөөр өндөр төсөөлснөөс болоод ингээд татварын орлого тасраад, 1.2 их наяд төгрөгийг урьдчилан төлөвлөсөн байна гэдэг ийм зүйлийг бид сая хавар гүйцэтгэлээр Их Хуралд тайлагнаад, тэгээд ингээд шийдвэр гаргуулсан. Ингээд энэ жилийн энэ тодотгол дээр ингээд дахиад харахаар нөгөө урьдчилан төлөвлөсөн 1.2-оос энэ жил 632.4 тэрбум төгрөгийн ААНОАТ урьдчилан төлүүлсэн нь 26 оны орлого бууруулахад шууд нөлөөлсөн байна гээд ингээд дүгнэлт гаргаад Их Хуралд толилуулчихсан байж байгаа. Тэгэхээр бид үүнийг цаашдаа ийм юу битгий яагаач гэдэг байдлаар ингээд шийдлээ гаргачихсан ингээд л Их Хуралд тайлагнаад явж байгаа. Энэ урьдчилан төлөвлөсөн нь орлогод нөлөөлсөн гэдгээ бид гүйцэтгэлээр ч гаргасан, энэ дээр ч дахиад гаргаж тавьж байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулж дууссан уу? Сангийн яам, 5 дугаар микрофоныг өгчихье.

Ж.Дэлгэржаргал: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Дүүргүүдийн шүүхийн барилга ер нь 2013 онд анх эхэлсэн, тэгээд 24, 25 он дээр яг шинэчилж төсөвт өртөг нь 74 тэрбумаар хэрэгжээд явж байгаа. 26 оны хувьд санхүүжих дүн дээр 24 тэрбумыг бид огт хөндөөгүй, гүйцэтгэл гараад явж байгаа. Энэ барилга дээр гадна шугам сүлжээний асуудал дутуу тавигдсан гэдэг үндэслэлээр дахиж магадлал хийгдээд, 27 оны өргөн барьсан төсөв дээр бид төсөвт өртгийн нэмэгдэл 18 тэрбум төгрөгийг нь өртгийг нь нэмэгдүүлсэн. Санхүүжих дүн талдаа яг 74 тэрбумын гэрээний үлдэгдлийг бүтэн тавиад, зөвхөн энэ төсөвт өртгийн нэмэгдлийг бид төсвийнхөө хязгаар боломжид суурилоод 28 он руу, 28 оны 1, 2 сард олгохоор явж байгаа. Гэхдээ нөгөө талд нь яг энэ өөрөө удаашралтай барилгыг сүүлийн 4, 5 жил дахин магадлал хийхээр явж байгаа бол гүйцэтгэл хангалтгүй явж байгаа гэсэн үг, 24 тэрбум одоогоор.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт, гүйцээгээд хариулчих уу, болсон уу, гүйцээх үү? 5 номерын микрофоноо өгчихье. Сангийн яам Дэлгэржаргал, гүйцээгээд хариулчихъя.

Ж.Дэлгэржаргал: Тийм, 24 тэрбумаас одоогоор 1, 2 тэрбумыг л санхүүжилт авсан байна. Тэгэхээр төсвийн жил дуусахад одоо 3, 4 сарын хугацаанд энэ 24 тэрбум өөрөө гарахад эргэлзээтэй. Тэгэхээр илүү нөгөө төсөв дээр тавьж байгаа санхүүжилтээ гүйцэтгэлээ гаргаад бүрэн авах нь яг захиалагчийн чиг үүргийн асуудал аягүй чухал. Хэрвээ энэ оны санхүүжилтээ авахгүй бол энэ өөрөө 2 жил ухрах эрсдэлтэй байгаа.

Л.Мөнхбаатар: ТҮ-гийн цалин дээр чинь хэд хэдэн ангилал нь орхигдсон байна гэсэн зүйлийг л Сайнзориг гишүүн асуугаад байна шүү дээ. Тэгэхээр яг сая Сайнзориг гишүүн өөрөө нэрлэж хэлсэн ангиллууд байгаад байна, тэдгээр нь яг энэ төсвийн тодотгол дээр орж ирж байгаад хамаарч байгаа юм уу, үгүй юм уу, орхигдсон юм уу гэдэг дээр тодорхой хариулт өгье. Хэн өгөх юм бэ? 4 номерын микрофон уу? 4 номерын микрофон өгье, нэр албан тушаалаа хэлээд гишүүний асуултад хариулаарай.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам, Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ. Сайнзориг гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. 26 оны төсвийн тодотголоор бид төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 50 хувь нэмэхээр ийм төсөл оруулж ирсэн. Тэгээд шинжлэх ухааны ажилчдын хувьд сая 26 оны 1 сараас эхлээд 15 хувь нэмэгдсэн байгаа. Тийм учраас бусад төрийн үйлчилгээний албан хаагчтай адил нэмэхээр тооцож 11, 12 сард шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 35 хувь нэмэхээр, бусад төрийн мэргэжлийн үйлчилгээ болон бусад нийтлэг төрийн үйлчилгээний албан хаагчдыг 50 хувь нэмэхээр төсөлд тусгасан байгаа. Таны асуусан ХЗДХ-ийн сайдын багцад үйл ажиллагаа явуулдаг шинжлэх ухааны төрийн мэргэжлийн, тэгээд төрийн эрүүл мэндийн эдгээр үйлчилгээний албан хаагчдын цалин яг бусад бүх салбартай адилхан ижил хувь хэмжээгээр нэмэгдэхээр тооцож холбогдох зардлыг тусгасан. ХЗДХ-ийн сайдын багцад.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу та? Сайнзориг гишүүн тодруулчихъя. Шүүхийн зөвлөл бас юу яана шүү. Сайнзориг гишүүн ингэчихье, ШЕЗ энэ шүүхийн барилгатай холбоотой асуудлаар нэг товч мэдээлэл өгчихье. Асуулт асуусан. ШЕЗ-ийн дарга Золзаяа, 2 номерын микрофон өгье.

П.Золзаяа: Сая дүүргийн цогцолбор барилгын талаар сая хэлж байна. Гүйцэтгэл муутай байгаа гэж, үнэхээр орой эхэлсэн нь үнэн. Гэхдээ маш хурдтай явж байгаа, гүйцэтгэгч компани нь гадаадын компани байгаа, манай яг гэрээт гэрээний гүйцэтгэгч ерөнхий гүйцэтгэгч нь хилийн цэргийн анги байдаг юм. Тэгэхээр энэ ажил нэлээн эрчтэй явж байгаа, ер нь бараг санхүүжилтийг бүрэн авах хэмжээнд ойрын өдрүүдэд санхүүжилтээ авахаар ингээд явж байгаа. Тэгээд үүнээс шалтгаалаад ер нь эргэлзээтэй байна гэдэг дүгнэлтийг бол арай эрт байх гэж бодож байна. 9, 10 сарын үед ер нь бараг 10 тэрбум хэд билээ гарахаар ийм тооцоо явж байгаа, хийсэн ажлынхаа барагцаагаар авахаар. Тэгэхээр энэ санхүүжилтийг 27 онд бүрэн тавиагүй байгаа нь үнэхээр эрсдэлд оруулж байна, 27 оноо дамжаад 28 он болох нь байна шүү дээ. Тэгэхээр тэр үлдэж байгаа ажил нь дандаа дотор интерьерийн ажлууд байгаа. Тэгэхээр 27 оны эхний хагас жил хийх.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: ХЗДХЯ нэг асуулт асуусан шүү дээ, Сайнзориг гишүүн, тэрийгээ харуулчих, Золзаяа дарга болсон уу? Хууль зүйн яам тийшээ сууж байгаад хариулчих, 6 номерын микрофон дээр суучих, түүний дараа Сайнзориг гишүүн тодруулъя.

Б.Батбямба: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба байна. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сая салбарын албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуулт асуулаа. Өмнө нь 15 хувийн нэмэгдэл боловсрол, шинжлэх ухааны салбарынханд орсон, манай салбар дээр нэмэгдээгүй, одоо манай салбарт ажиллаж байгаа Хууль зүйн үндэсний хүрээлэн, бусад байгууллагын шинжлэх ухааны ажилчид энэ нэмэгдэлд хамрагдаж чадаагүй. Одоогийн нэмэх гэж байгаа нэмэгдэлд ч гэсэн хамрагдахгүй байгаад байгаа ийм зүйлүүд байгаа. Бид Сангийн яам руу саналаа хүргүүлсэн, тэгээд одоогийн байдлаар нэмэгдэж байгаа төрийн үйлчилгээний албан тушаалын хүмүүсийн цалин л нэмэгдэхээр манайд тооцоолол нь ирчихсэн байгаа. Яг Сайнзориг гишүүний ярьсан энэ ангилалд хамрагдаж байгаа албан хаагчид манай салбар дээр нэмэгдэж чадаагүй байгаа, аль алинаас нь ингээд хоцорч байгаа юм.

Л.Мөнхбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Албаны хүмүүс хэллээ, багц байдлаараа ороод явчихдаг, дараа нь хүрэлцэхгүй гэдэг яг ялгаварлан гадуурхсан, УИХ-ын гишүүд энийг яг нөгөө багш, эмч нар, багш нарын цалин нэмэгдэж байгаа юм шиг юм болчих вий дээ. Цөөхөн хүн ч гэсэн битгий ингэж алагчилж үзээрэй. Аливаа зүйлийг ингээд тодорхой тусгаж оруулж ирэх ёстой байсан гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлчихье.

2 дугаарт, энэ яах вэ ерөнхий бодлогын хүрээнд нэг асуумаар байна. Энэ сэргээгдэх эрчим хүчний асуудлыг дэмжих нэлээн юмнууд явж байна, зэрэгцээд эрчим хүчний энэ татаасны асуудлуудаар нэлээн хөрөнгө мөнгө тавьж орж ирж байх шиг байна тодотголоор. Энэ бодлогын чинь цаана Тавантолгойн станцыг барих бодлого хойшлоод юм уу, зогсоод байгаа зүйл байгаа юу? Үүнийг бодлогын хүрээнд ер нь юу гэж харж орж ирсэн юм бэ, энэ ЭХЯ-ны ч юм уу, Сангийн яам дээр ямар байдлаар энэ татааснуудыг нэмэгдүүлнэ гэж орж ирчхээд, үүний цаана бараг ингээд хараад байхаар Хятадын мэргэжлийн хүмүүс хэлээд байна лээ шүү дээ. Ингээд Хятадын эрчим хүчний системтэй энэ говь болон төвийн эрчим хүчний систем чинь хэт их хамааралтай болоод ирвэл энэ Тавантолгой станц чинь ер нь баригдах, баригдахгүй энэ асуудал чинь ер нь яаж явах юм бэ? Хэдийгээр энэ Байнгын хорооны асуудал биш боловч.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Сангийн яам хариулах уу? 5 номерын микрофоныг өгье.

Ж.Дэлгэржаргал: Төр, хувийн хэвшлийн түншлэл талаас нь хариулъя. Түншлэлийн хууль 22 онд батлагдаад өнгөрсөн онуудад нэмэлт, өөрчлөлт хийгээд, одоо яг бид 27 оны төсөв дээр хөрөнгө оруулалтаа төлөвлөхдөө ер нь бүх эх үүсвэрийн хүрээнд уялдуулж төлөвлөсөн. Энэ хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэл дээр одоогоор 31 их наядын төсөл явж байгаа, дийлэнх нь дэд суурь дэд бүтэцтэй холбоотой. Тэгээд Тавантолгой 450 МВт-ын ДЦС төр, хувийн хэвшлийн

түншлэлээр яг ЗГ руу төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх төлөвлөлт нь орохоор түншлэлээр хэрэгжүүлэх ийм эх үүсвэртэйгээр төлөвлөгдөөд явж байгаа.

Л.Мөнхбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Ойлголоо. Ер нь 2, 3 юм орхигдлоо, орон сууцны залилантай холбоотой нэлээн асуудлууд үүсээд, би хуулийн төсөл нэр бүхий гишүүдтэй хамт өргөн барьсан, ЗГ-аас надтай төстэй хууль өргөн барих гэж байгаа гэж ойлгосон. Энэ хуулийн хэрэгжилт нь программ хангамжаас шалтгаална. Улсын бүртгэлийн байгууллага дээр энэ хуулийг хэрэгжүүлэх программ хангамжийн асуудлыг шийдээрэй гэж явсан, энэ ер нь энэ тодотголоор орж байгаа юу, үгүй юү, нэг хариулаад өгөөч.

Архины сан гээд байгаа, хар тамхи, архидалт газар авлаа гээд байдаг, 20 хэдэн тэрбум төгрөг босгоод, цаашдаа энэ архи үйлдвэрлэгчдээс энэ эмгэгтэй тэмцье, эмнэлэг, ор дэр бэлдье, эмнэлэг барья гэхээр мөнгийг нь зарцуулдаггүй. Яг энэ тэмцэх хүсэл зориг ер нь ЗГ-ын холбогдох байгууллагуудад байна уу, энэ архины сангийн зарцуулалтыг нээж өгсөн үү энэ тодотголоор, энийг нэг хариулаад өгөөч?

Шүүхийн барилгын асуудлыг улсын хэмжээнд нэг шийдье, энэ дээр би нэг хуулийн зохицуулалт заалтыг хийе гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр Сангийн яамтай цаашдаа энэ тодотгол байдаг юм уу, төсөв яриад л нэг ганц 2 барилгын асуудал тавиад л удааширсан, удааширсан биш.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Сангийн яам хариулъя, 5 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Улсын бүртгэл дээр 26 онд яг 5,10-ны Улсын бүртгэлийн хиймэл оюунд суурилсан цахим систем, тоног төхөөрөмж гээд 5.6 тэрбум батлагдсан, 5.1-ээр гэрээ байгуулаад тодотголоор яг хасагдаагүй, буураагүй. Яг энэ дүн дээрээ энэ жил бүтэн хэрэгжихээр явж байгаа. Дүүргүүдийн шүүхийн барилгын хувьд ер нь яг төсвийн санхүүгийн сахилга бат, төлөвлөлтийн зарчмаа Сангийн яам барьж байгаа. Тэгэхээр гэрээний үнийн дүнгийн үлдэгдлийг бид 27 онд бүтэн тавьсан, гэрээний дүндээ багтахгүй төсөвт өртгийн нэмэгдэл 18 тэрбум магадлал гараад аудитын дүгнэлт гарсан учраас энийг бид төсөвт өртгийг нэмэгдүүлсэн. Тэгээд төсвийн жилийн цаглавартайгаа уялдуулаад, хэрвээ гэрээний үлдэгдлээрээ 27 онд бүтэн хэрэгжиж чадвал 28 оны 1 сард энэ үлдэгдлээ авах бүрэн боломж нь байгаа. Хамгийн гол нь бид санхүүжилтийг тавихдаа төсвийн хуулийн шаардлагаас гадна хэрэгжилт яг ямар явж байгаа юм бэ, гүйцэтгэл яг үнээр тухайн жилдээ бүтэн гарч чадах уу гэдгийг давхар хардаг. Тэгэхээр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тийм, асуултад нь гүйцээгээд хариулчихъя, 5 номерын микрофон. Хэн хариулах вэ? 4 номерын микрофоныг өгье. Архидан согтуурахтай тэмцэх сангийн асуудлыг тодруулаад байна шүү дээ, тийм ээ?

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам Бат-Эрдэнэ. Сайнзориг гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. 2026 оны төсвийн тодотголоор архины сангийн зардлыг нэмэх төсөв тусгаагүй. Бид 2027 оны төсөв дээр яг энэ сангийн зарцуулалтыг нэмэхээр төслийг Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Архидан согтуурахтай тэмцэх тэр санд чинь одоо яг хэдэн төгрөг байгаад байгаа юм, тэгээд тэрийгээ бүрэн зарцуулж байна уу гэж Сайнзориг гишүүн асуугаад байна шүү дээ. Тэрийгээ хуучин чинь 20 гаруй тэрбум төгрөг байдаг байсан, тэрийгээ бүрэн зарцуулж байгаа юм уу, тухайн жил бүр Сангийн яам тодорхой квот зааж өгөөд, тэр хэмжээндээ Хууль зүйн яам хэрэгжүүлээд байгаа юм уу гэсэн агуулгаар асуугаад байна гэж би ойллоо шүү дээ. Тийм үү, Сайнзориг гишүүнээ? Тэрийг нь тодруулаад хариулчих, 4 номерын микрофон өгье.

П.Бат-Эрдэнэ: Архины санд одоогийн байдлаар нийт өссөн дүнгээрээ 22 тэрбум төгрөг хуримтлагдсан байгаа. Энэ 25 оны төсвийг Их Хурал дээр батлахад Их Хурлын ажлын хэсэг энэ сангийн мөнгийг бууруулаад тэглэж байсан юм. Тэгээд тэр дагуу 25 он, 26 онд зарцуулалт хийгдэхгүй байгаад, тэгээд 27 оноос салбар яамнаас ирсэн саналыг харгалзаж үзээд энэ сангаас зарцуулах зардлыг тусгаж төсвийн төслийг Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа.

Л.Мөнхбаатар: 27 онд хэд байгаа юм, тоо нь?

П.Бат-Эрдэнэ: 2027 онд энэ сангаас 5 тэрбум төгрөг зарцуулахаар холбогдох төсвийг Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Л.Мөнхбаатар: Тэгээд яах вэ, энэ Сайнзориг гишүүний хэлээд байгаа агуулга ийм байна шүү дээ. Архидан согтуурахтай тэмцэх ажилд, энэ Сайнзориг гишүүн ч ярьдаг, Алтангэрэл гишүүн ч ярьдаг, энэ үе үеийн л сайд нар нь ярьдаг асуудал л даа. Энэ сангийн мөнгө яг улсын төсвөөс бүрдэж байгаа мөнгө биш. Архи үйлдвэрлэгчдээс нийгмийн хариуцлагын хүрээнд бүрдүүлдэг ийм сан, тэгээд тийм учраас энэ сангийнхаа үйл ажиллагааг бүрэн зарцуулах ёстой. Тэгэхээр Сангийн яам авч үлдчихээд байна, тийм учраас үүнийгээ бүрэн зарцуулах ёстой шүү гэдэг агуулгаар хэлж байна. Тэгээд сая 25, 26 онд ингээд тэг болчихсон, зарцуулаагүй байна шүү дээ, энэ нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх үүрэг нь хэрэгжээгүй гэсэн үг. Ирэх онд 5 тэрбум гэсэн зүйл тавьчихсан явж байгаа юм байна. Ийм нэгдсэн тийм мэдээлэлтэй боллоо, Сайнзориг гишүүн, энүүгээрээ дараа нь хэлэлцүүлгийн явцад саналуудаа гаргаж болно шүү дээ та, тийм ээ. Даваагийн Цогтбаатар гишүүн горимын гаргая.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ УИХ, манай Мөнхбаатар дарга шинээр томилогдсон Байнгын хорооны дарга, энэ ХЗБХ-ныхоо хурлыг нэг жоохон дэгтэй, зохион байгуулалттай явуулмаар байна. Энд чинь дуудаж байгаа дарга нараас чинь хэн ч алга байна шүү дээ. Ажилд томилъё гэхээр бүгдээрээ ажилд томилогдъё гээд л анкетаа бариад гүйчихдэг, тэгээд ажлынх нь хариуцлагыг, урсгал зардлыг нь, энэ өөрчлөлт орж байгаа хэсгийг нь ярья гэхээр бүгдээрээ ирдэггүй. Та энэ нэрснүүдээ уншаад байсан чинь АТГ-аас нэг ажилтан ирчихсэн байна. Аль сайдын гэнэ вэ, нэг зөвлөх ирчихсэн байна. Уг нь цагдаагаас би тэр даргыг нь дуудаж байгаад юм яримаар байна. Тэгээд чаддаг бол дарга нар нь наанаа суу. Энийг хар, “100 ямаанд 60 ухна” гэдэг шиг нөгөө Эрдэнэс Монгол билүү, Чингис баялгийн сан ч билүү, энэ чинь хуулийн байгууллагын төсвөө ярьж байхад тэд юугаа хийж байгаа юм, очиж ажлаа хийхгүй юм уу? Та нар ажлаа хийж чадахгүй байна гээд тэр чинь бүр гадаадын байгууллагуудаар удирдуулна гээд явж байна шүү дээ. Дахиад дээрээс нь Монголбанк, нэг уяач нөхрийг бөөн юм болж болж томилсон чинь одоо бүр дөрөв, тавуулаа ирчихсэн, инфляц галзуураад байна. Та нар очиж ажлаа хий, энд түй ч хэрэг байхгүй. Байгаа бол 3 Ерөнхийлөгчийнх нь нэг нь ирээд суу, ирж суухаараа асуултад хариул, битгий онол ярь. Ингээд жоохон

дэгтэй, зохион байгуулалттай явахгүй бол энэ чинь тоон дотор үсэг гэдэг шиг Монголбанк дөрөв, тавуулаа юугаа хийж байгаа юм бэ? Тэгээд нэг баахан ажилтан, мэргэжилтнүүд нь ирчихсэн, болдог бол бүгдээрэнг нь мэргэжилтэн авчирч, энэ дарга нар нь явж ажлаа хий.

Эсвэл дарга нар нь яг тэр ерөнхий гүйцэтгэх гэдэг юм уу, тэр хамгийн яг эрх мэдэлтэй дарга нар нь, санхүүгээ мэддэг тэр дарга нар нь ирээд суу л даа. Юун ажилтан бэ? Тэгээд энэ дарга нарыг нь иртэл энэ хурлаа хойшлуулахгүй бол бөөн юм болж болж энэ чинь бараг цагийн дараа эхэлсэн хурал шүү дээ. Тэгээд гишүүд нь ч гэсэн ажилгүйдээ энд суугаад байгаа юм уу? Алтангэрэл гишүүн чинь сайд байхдаа өөрөө орж ирээд л, ажилтай ч гэсэн сууж байдаг байсан шүү дээ. Одоо Хууль зүйн сайд нь ч байхгүй шүү дээ. Тэгээд хуулийн байгууллагын бид урсгал зардлыг ярьж байгаа шүү дээ. Та ч гэсэн өөрөө сайд байсан хүн. Ийм хариуцлагагүй хурлуудыг бид үргэлжлүүлж явуулмааргүй байна. Тийм учраас энэ хурлыг хойшлуулаад, энэ та нарын дуудаад байгаа дарга чинь ирээд, өөрсдөө хариуцлага хүлээгээд, бидэнд үнэхээр урсгал зардал, цалингийн нэмэгдэл ийм хэрэгтэй байна, бид ийм хүмүүсийг заавал ажиллуулмаар байна, тэгэхийн тулд бид ийм цалингийн нэмэгдэл хэрэгтэй байна гээд жаргал зовлонгоо ярьж байгаад шийдэхгүй энд чинь бид ажилтнуудаас нь юуг нь асуух вэ? АТГ-ын дарга томилогдохоороо энэ УИХ-ын чуулган дээр орж ирээд л томилогдоод явдаг, ажлаа ч тайлагнадаггүй шүү дээ, тэгээд бид ингээд ямар юмаа хийгээд суугаад байгаа юм бэ? Жоохон хариуцлагатай байя тэгэх үү дарга аа? Хурлаа хойшлуулъя.

Л.Мөнхбаатар: Горимын санал гаргаж байгаа юм байна шүү дээ, тийм ээ? Даваагийн Цогтбаатар гишүүн горимын санал гаргаж байгаа юм байна. Тийм учраас гишүүн горимын санал гаргасан бол санал хурааж шийддэг, тийм дэгтэй. Тийм болохоор санал хураалт явуулъя. Хэлэлцүүлэг, хэлэлцүүлэгт оролцож байгаа албан тушаалтнуудаас ирээгүй хүмүүсийнхээ нэрсийг, нэрсээ өгсөн байгаа шүү дээ, урьдчилж байгууллагууд нэрсээ өгсөн байгаа шүү дээ, эндээс ирээгүй хүмүүсийнхээ нэрсийг Ажлын алба танилцуулаарай. Гэхдээ энэ удаагийн хэлэлцүүлэг нэг ийм онцлогтой шүү. Яах вэ, ер нь төсвийн хэлэлцүүлэг чинь 5 шат байгаа. Тэндээс өнөөдрийнх Байнгын хороо танилцаад, Төсвийн байнгын хороонд танилцсан тухайгаа хүргүүлнэ. Төсвийн 2, 3 дугаар хэлэлцүүлгээр уул нь яг байгууллагуудын төсвийнхтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргаж нэмэх, өөрчлөх, хасах энэ процессуудыг зохион байгуулж явуулдаг, түүнийгээ Төсвийн байнгын хороо, ажлын хэсэгт хүргүүлдэг ийм дэгтэй гэдгийг гишүүдэд танилцуулъя.

Даваагийн Цогтбаатар гишүүн нэгэнт санал гаргасан учраас санал хураалт явуулъя. Гишүүд, санал хураалтдаа бэлдээрэй. Болсон уу, гишүүд. Дэд сайд, ХЗДХЯ-наас ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч байгаа юм байна. Танай сайд, дэд сайд чинь яасан юм бэ, тэрийгээ та бүгд. Ингэе, одоо санал хураалтаа явуулчихъя ямар ч байсан, тэгэх үү? Ирээгүй байгууллагын тухай тайлбар сонсоно тэгвэл наадах чинь нэлээн урт юм болчих байх. Тэгээд санал хураалтыг явуулъя, саналаа гаргасан бол эхлээд санал хураалтынхаа дүнг сонсчихоод ярь та Цогтбаатар гишүүн. Ингээд санал хураалтдаа бэлдье гишүүдээ, ороогүй гишүүд байгаад байна шүү энд.

УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатарын гаргасан уг хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Даваагийн Цогтбаатар гишүүний саналыг 4 гишүүн буюу 26.7 хувь дэмжсэн байна, 4 гишүүн дэмжсэн байна. Уг саналыг хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонх

дэмжээгүй тул хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя. Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Ер нь яах вэ, би сая Даваагийн Цогтбаатар гишүүний хэлсэн дээр дараа дараагийн Байнгын хороо, дараа дараагийн юун дээр байгууллагууд, удирдлагууд анхаарах ёстой байх. Ер нь улс төрийн байгууллага улс төрийн ийм томоохон шийдвэр гаргах гэж байгаа учраас энэ дээр яг улс төрийн албан тушаалтнууд өөрсдөө хариуцлагатай оролцох хэрэгтэй, шаардлагатай байгаа. Төрийн албан хаагчид ойлгомжтой, нэг өөрсдөдөө байгаа хэдэн тоогоо тайлбарлаад суух нь ойлгомжтой байх. Тэгэхээр энэ дээр бид цаашид энийг анхаарах нь зөв гэж бодож байна. Үндсэн асуултдаа оръё.

Сангийн яам, Монголбанк хоёроос 2 асуулт асуумаар байна. Эхлээд Сангийн яамнаас 2024 онд ажлаа гүйцэтгээд хүлээлгээд өгчихсөн, 2025 онд ажлаа гүйцэтгээд хүлээлгээд өгчихсөн хувийн хэвшлүүд энэ Сангийн яамнаас мөнгөө авч чадахгүй байна гэсэн гомдол маш их ирж байна. Ялангуяа өчигдөр би нөгөө боловсролын салбартай холбоотой энэ төсвийн тодотголыг хөндсөнөөс хойш боловсролын салбар дээр ажлаа хийсэн мөртөө мөнгөө авч чадаагүй гэсэн байгууллагууд маш их байна. Ер нь ийм үлдэгдэл байгаа юм уу? Энэ үлдэгдэл нь өөрөө энэ бид нарын энэ батлах энэ тодотгол дотор яаж орж ирж байгаа юм, нөгөө бууруулаад ороод ирж байгаа юм биш биз дээ? Энэ хувийн хэвшлүүд мөнгөө авч чадахаа болих юм биш биз дээ гэсэн нэг ийм асуулт байна.

2 дугаарт, Монголбанк энэ дээр хариулаад өгөөрэй, 2 дахь асуулт. Төрийн албан хаагчдын цалинг нэмлээ гэж тооцоход хувийн хэвшлүүд цалингаа нэмэх хэрэгцээ, шаардлага үүсэх үү? Чуулган дээр би энийг асуусан, асуултад хариулаагүй. Тэгэхээр энийг бид Байнгын хорооны хуралдаан дээр асуумаар байна. Хувийн хэвшлүүд цалин хөлсөө нэмэх хэрэгцээ, шаардлага зайлшгүй үүсэх үү? Энэ нь өөрөө инфляцад хэрхэн нөлөөлнө гэж харж байгаа вэ? Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл инфляцад ер нь ямар нөлөө, хэдэн хувийн нөлөөг, ямар хугацааны дараа үзүүлдэг гэж та нарын тооцоолол байгаа юу? Энэ дээр нэг хариулаад өгөөч. Нөгөө талаараа цалин хөлс нэмэгдээд бүтээмж нэмэгдэх үү? Бүтээмж яаж нэмэгдэнэ гэдэг тооцоолол байгаа вэ, Сангийн яаманд, төрийн албан хаагчдын бүтээмж? Нэг ийм 2 асуулт байна.

3 дугаарт, хууль зүйн нэгэнт ХЗБХ учраас яг манай ХЗБХ-нд хамаарах энэ олон хуулийн байгууллагын төрийн байгууллагуудаас энэ төсвийн тодотголоор яг төсөв нь хасагдаж байгаа, танагдаж байгаа ямар ямар байгууллагууд байна, хэчнээн төгрөгөөр хасагдаж байна, ямар зардлууд нь хасагдаж байгаа вэ гэдэг дээр байгууллагууд өөрсдийнхөө яг хасагдаж байгаа байгууллагууд нь л хэлчих, тэгэх үү? Манай байгууллагаас тэчнээн төгрөг энэ зардлаас хасагдаж байна, бас яагаад гэдэг шалтгааныг нь би сонсмоор байна. Ялангуяа надад ирсэн энд байгаа материалаас хамгийн өндөр хасагдаж байгаа нь ХЭҮК хамгийн өндөр дүнтэй буюу 224 сая төгрөгийн төсөв хасагдаж байна. Манай энэ хуулийн салбар дотроос хамгийн бага төсөвтэй байдаг мөртөө танахаараа ингээд хамгийн өндөр төсвөөр танагддаг ийм байгууллага болчихоод байдаг. Энэ Комиссын төсөв тэр дундаа яагаад ингэж хасагдаж байгаа вэ гэсэн ийм 3 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Даваагийн Цогтбаатар, Баасанжаргал нарын гишүүдийн тавьж байгаа асуудал мэдээж зарчмын хувьд зүйтэй асуудал. Гэхдээ ХЗДХ-ийн сайд болон манай эрхлэх асуудлын хүрээний байгууллагын дарга нар гадаадад

айлчилж байгаа гэсэн ийм мэдээлэл өгсөн. Энэ талаар ТНБД нь тодорхой мэдээлэл өгөөд, тэгээд Баасанжаргал гишүүний асуултад хариулаарай, эхлээд хэн хариулах юм, ТНБД хариулах уу? 6 номерын микрофоныг өгчихье, дараа нь Сангийн яам хариулъя.

Б.Батбямба: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. ХЗДХ-ийн сайд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу БНХАУ-д зохион байгуулагдаж байгаа Цахим гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын том форумд оролцохоор ЦЕГ-ын дарга, ХХЕГ-ын дарга, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга нартай ингээд яг өнөөдөр оролцож байгаа. Маргааш буцаж ирэхээр ийм байгаа. Дэд сайдын хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан энэ архидан согтуурахтай тэмцэх чиглэлийн том ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсгийн хүрээнд хурал, энэ яг энэ төсвийн тодотголтой холбогдуулаад шаардлагатай асуудлуудаараа ажлын хэсэг хуралдаж байгаа учраас хүлцэл өчөөд өнөөдөр ирж чадаагүй ийм байгаа.

Архины сангийн зардлын асуудлыг бид энэ 26 оны төсвийн тодотгол аль дээр ч тэр, 27 оны төсвийн юун дээр ч гэсэн ер нь байнга тавьж байгаа. Тэгээд 27 оны төсвийн төсөл дээр нийт 13 орчим тэрбум төгрөгийн ажил, арга хэмжээ зохион байгуулна гэж саналаа өгсөн. Энэнээс одоогийн байдлаар Сангийн яам 5 тэрбум төгрөг тавих боломжтой байна гээд төсвийн төсөлд тусчихсан явж байгаа ийм байна. Нийтдээ манай салбарын хэмжээнд 20.6 тэрбум төгрөгийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл байгаа. Дээрээс нь зарим 6 сарын 1-нээс өмнө гэрээ байгуулж амжаагүй хөрөнгө оруулалтын зардлууд хасагдаж байгаа ийм дүнтэй байгаа, нийтдээ 11 тэрбум төгрөг.

Л.Мөнхбаатар: 3 дахь хэлэлцүүлэг ирэх 7 хоногоос ингээд хийгдэнэ, төсвийн тодотголууд хэлэлцэгдэнэ. Түүнээс гадна 2027 оны төсөв өргөн баригдахаар ингээд төсвийн ерөнхийлөн захирагчид биечлэн оролцох хэрэгтэй. Энийг танай байгууллагын удирдлагууддаа бүрэн эрхэлсэн асуудлын байгууллагууд бүгд бүрэн хариуцна шүү. ХЗДХЯ эрхэлсэн харьяа байгууллагуудынхаа төсвийн ерөнхийлөн захирагчид, төсвийн захирагч нараа бүрэн байлцуулна. Холбогдох Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд ч гэсэн бүрэн оролцох ёстой. Энэ ХЗДХЯ-ны харьяа байгууллагуудаас бусад нь бүрэн энд оролцож байгаа харагдаж байна. Асуултад үргэлжлүүлэн хариулъя, Сангийн яам уу? 5 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя, Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр 25 оны гүйцэтгэл бид нийтдээ улсын төсвийн хөрөнгө оруулалт 3 их наядыг олгохоор батлагдсанаас гүйцэтгэлийн дагуу бид 2.1 их наядыг олгосон. 25 оны төгсгөлд яг 12 сард төсвийн орлоготой уялдуулаад зарим санхүүжилтүүдийг эрэмбэлэх шаардлага гарсан. Нийтдээ 25 оны гүйцэтгэлээс 779 тэрбум тухайн ондоо гарч чадаагүй. Бид оны төгсгөлд ямар эрэмбэ гаргасан бэ гэхээр 25 оны төсвийн хуулиараа тухайн онд бүрэн дуусаж байгаа төслүүдийг бүрэн олгосон. Тухайн төсөл нь гүйцэтгэл ирсэн боловч 25 ондоо гарах боломжгүй, 26 онд төслөөрөө батлагдсан төслүүдийг 26 оны санхүүжилтүүдээс нь гүйлгэж олгосон гэсэн үг. Тэгэхээр яг 25 оны жилийн эцэст гүйцэтгэл нь ирчхээд бүрэн гараагүй ч юм уу, олгоогүй санхүүжилт байхгүй байгаа. Тэгэхээр 26 оноос нь бид гүйлгээд олгосон учраас.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчих уу, болсон уу хариулт?

Ж.Дэлгэржаргал: Энэ олгоогүй 779 бол 27 оны өргөн барьсан төсөв дээр буцаагаад гэрээний үлдэгдлээр нь шахаад ингээд тавиад явж байгаа. Тэгэхээр аль болохоор төсвийн орлоготой уялдуулаад тасалдахгүй байхаар ийм зохицуулалт хийж олгосон.

Л.Мөнхбаатар: Өөр нэмж хариулах хүн байгаа уу? 4 номерын микрофоныг өгье, Сангийн яам хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам Бат-Эрдэнэ, Баасанжаргал гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. ХЭҮК-ын 2026 оны жилийн батлагдсан төсөв нь 10.5 тэрбум. Бид энэ удаагийн төсвийн тодотголоор бүх төсвийн ерөнхийлөн захирагчдаас яг ижил зарчим бариад тодорхой зардлуудыг бууруулсан. Тэгээд энэний цаана мэдээж энэ учир шалтгаан нь боловсролын салбарт дутагдаж байгаа цалинг нэмэх, эрүүл мэндийн салбар дээр цалин нэмэх, тэгээд эрчим хүчний салбарт тулгамдсан энэ өвөлжилтийн бэлэн байдлыг хангах гэх мэт яг ийм тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх зорилгоор хассан учраас аль нэг салбарыг онцлоогүй, яг бүх салбараас ижил зарчим барьж зардлуудыг бууруулсан.

Тэгээд ХЭҮК-оос нийт 2.1 хувийн зардлыг бууруулсан. Ингээд энэ он дуустал 10.2, 10.3 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаа явуулна. Тэгээд бид яг энэ хүрээндээ ямар нэг үйл ажиллагаа доголдуулахгүйгээр энэ ажил үйлчилгээгээ бүрэн хэрэгжүүлээд явах боломжтой байна гэж тооцсон байна, баярлалаа.

Л.Мөнхбаатар: ХЭҮК-ынхон энэ дээрээ холбогдох мэдээллийг өгье. Танайхаас чинь нэлээн хасагдаад байна шүү дээ. Энэ чинь хэвийн үйл ажиллагаа явуулах хэр боломжтой юм бэ гээд Баасанжаргал гишүүн асуугаад байна. 1 номерын микрофон, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сая Сангийн яамны хэлсэнчлэн 10.5 тэрбум, ХЗБХ-ноос батлагдсан нь 13.4 тэрбум, хасагдсан нь 224 сая. Одоо 9 сараас эхлээд цалингаас өөр зардал гарахгүй, өмнөх өр төлбөр 300 сая хэвээрээ үргэлжилнэ, энийг хэлэх нь зүйтэй байх. Өөрөөр хэлэх юм бол 9, 10, 11, 12 сард ямар нэг томилолт, сургалт, өмнө байгуулсан гэрээнийхээ үлдэгдэл, шатахуун, тээвэр гээд бүх зардал байхгүй. Цалингаас өөр зардал үлдэхгүй байгаа. Хэвийн үйл ажиллагаа явуулахад доголдоно л гэж үзэж байна, энийгээ хэлэх нь зөв байх.

Л.Мөнхбаатар: Хариулт болсон уу? Баасанжаргал гишүүн яах вэ, ер нь Хүний эрхийн Үндэсний Комисст хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байна гэдэг асуудал яригдаж байгаа учраас манай Хүний эрхийн дэд хорооны дарга та нөгөөдөх дараагийн 3 дахь хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй саналаа гаргаад явах боломж нээлттэй байгаа шүү гэдгийг танд хэлье. УИХ-ын гишүүн Баярмагнайн Баярбаатар асуултаа асууя. Нэмж хариулах юм уу? 3 номерын микрофоныг өгчихье.

Э.Анар: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя, Монголбанк Анар. Гишүүний асуултад болохоор зэрэг төрийн албан хаагчийн цалин нэмэгдэж байгаатай холбоотойгоор хувийн ААН болон бусад байгууллага, эмнэлэг, сургуулиуд, багш нарын цалин нэмэгдэх үү? Төв банкны зүгээс судалгаа, шинжилгээний хүрээнд үзэхэд мэдээж тодорхой хувиар нэмэгдэнэ. 26 оны 4 дүгээр улирал, оны эцэс гэхэд нийт инфляцад 0.5-аас 0.7 хувиар нэлээд нөлөөлөх болов уу гэсэн урьдчилсан тийм үнэлэлт, шинжилгээ хийгдэж байгаа. Тэгэхээр зэрэг

ойролцоогоор 26 оны төсвийн тодотголын хүрээнд нийтдээ 0.7 хувийн нэгжээр инфляцад нөлөөлж, энэ инфляцад дарамт үүсэх болов уу гэсэн тийм урьдчилсан байдлаар бид дүгнэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт болсон уу? УИХ-ын гишүүн Баярмагнайн Баярбаатар асуултаа асууя.

Б.Баярбаатар: Өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр төсвийн тодотгол хэлэлцэж байна, эхний танилцуулга явагдаж байгаа гэж ойлгож байна. Тэгээд би ч гэсэн дарга нар нь цаанаа ажлаа хийж байж болно шүү дээ, энэ дарга нарыг нь ирэхээр юугаа хийгээд энүүгээр яваад байгаа юм, дарга нарын үүд сахиад явж ажлаа хийгээч, тэр ажлаа мэддэг хүнийг нь явуулаач гээд загнаад байдаг юм байна лээ. Тэгээд яах вэ, дараа дараагийн хэлэлцүүлэг дээр ирэх л байлгүй. Тэгээд энэ Монголбанк эд нар чинь энэ тодотголын ажлын хэсэгт ороод ажиллаж байгаа болов уу гэж харж байгаа шүү дээ. Тэгээд Их Хурлын дэргэдэх байгууллага энэ төсвийн тодотголыг хэлэлцэх үед нь ирж оролцох үүрэгтэй. Энэ өв соёл, морь уях энэ өв соёлоо тээж яваа хоббигоор нь хүнийг ялгаварлан гадуурхаад байж болохгүй байх. Морь уях гоё шүү дээ. Тэгээд би танд хандаж хэлж байна. Тэгээд уяач болохоороо төрийн захиргааны байгууллагад ажиллаж болохгүй гэсэн ийм хууль зүйн заалт байгаа бол тэрийг нь гаргаж ирээд тавьчих нь зөв байх.

ШЕЗ дээр нэг ийм юу байна, энэ тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмжээс 1.6 тэрбумыг хасаж байгаа юм байна. Энэ ямар зохицуулалт хийж хасагдаж байна вэ? Тэтгэврийг нь хойшлуулчхаж байна уу, эсхүл нөгөө 36 сарын тэтгэмж л байх л даа, энийг нь олгохыг нь эсхүл хойшлуулчхаж байна уу? Энэ ингэж хойшлуулаад баймгүй зүйл байдаг юм. Өнөөдөр энэ төрийн албаны гол дархлаа, одоо ганц энэ төрийн албанд чинь тавигдаж байгаа үндсэн гол дархлаа нь энэ болж байгаа шүү дээ. Энэ чинь ҮХЦ нэг Үндсэн Хуулийн зөрчсөн гэж нэг дүгнэлт гаргаад, гаргах гээд ч билүү, тэгээд Эрдэнэбат гишүүн бид хоёр очиж нэг хамгаалж, авч үлдэж байсан юм. Тэгээд энэ дээр нэг хариулт авмаар байна. Дараа дараагийн хэлэлцүүлэг гэдгээр анхаарах ёстой юм болов уу, бусад нь ч яах вэ энэ тодотголыг дэмжиж байгаагийнхаа хувьд бусад нь танаж болохоор зардлууд харагдаад байна уу гэж харж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүйгээр нэг Монголбанк байж байгаа учраас би нэг чиглэл өгөх хүсэлтэй байна. Энэ өнгөрсөн зун нэлээн олон зүйлүүдийг би ажиглалаа. Энэ 4 аймгийн сумдад хууль бус алт олборлолт их явагдлаа. Тэгээд энэтэй холбоотой энэ алтны тушаалт яг Монголбанк дээр, жишээлбэл, Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Хүдэр сум, Баянхонгорын Байдрагийн гол, тэгээд нөгөө урт нэртэй хууль үйлчлэхээ байчихсан, гол дотор ороод алт ухаж байна шүү дээ, ой модон дотор алт ухаж байна. Тэгээд бохир усаа гол руу нийлүүлж байна. Би бичлэгийг нь үзлээ, бүр үнэхээр бүр энд Монгол Улсын Ерөнхийлөгч Тэрбум мод гээд хөтөлбөр дэвшүүлээд, тэрбум мод тарих гээд зорьж явж байхад тэнд байгалийн алуурчид буюу хууль бус алт олборлогчид тэрбум мод хядаж байна. Тэгэхээр эдгээр дээр нэг мэдээллийг би, Монголбанк дараа нь надад нэг гаргаад өгөөрэй. Энэ яг алт тушаалт нь өөрөө яг хэр байдаг юм бэ, ялангуяа яг саяын 4 сум дээр. Би зүгээр албан бус мэдээллээр үзэхэд Баянхонгор дээр нэлээн өндөр байгаа гэж би нөгөө тухайн орон нутгийн Монголбанкны салбараас нь асуухад хэлсэн тэгээд энийг.

Сая манай Сайнзориг гишүүн тэр архины сангийн 22 тэрбум төгрөгийн асуудал хөндчих шиг боллоо. Би хоёр юманд толгой гашлаад яваад байсан юм, ашгүй харин эх үүсвэрийг нь олчих вуу даа л гэж бодож байна. 1 дүгээрт, энэ Шүүх шинжилгээний төв байх, бусад хуулийн энэ байгууллагуудын барилга сав их гайгүй болоод явчихсан шүү дээ. Энэ 1 дүгээр эмнэлгийн хашаанд байгаа энэ Шүүх шинжилгээний төвийн барилга гэж нэг хоцрогдчихсон, жижигхэн барилга, тэгээд энийг нэг шинэчлээд барьчих юм сан гэсэн нэг ийм бодол санаа надад яваад байдаг юм. Дээр нь энэ сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, мансууруулах бодис энэ хуулийг би ажлын хэсэг ахалж байгаа, энийг урьдчилан сэргийлэх, энэ донтолтоос сэргийлэх, энэ эмчилдэг ийм төвтэй больё гэсэн ийм 2 зүйл дээр сая ашгүй энэ нэг санхүүжилт нь энэ дээр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Та яах вэ тодруулаад асуучих уу, гүйцээгээд асуучих.

Б.Баярбаатар: Тэгэхээр энэ 22 тэрбум төгрөгийг, энэ 5 тэрбум нь одоо энэ үлдэж байгаа цөөхөн сар зарцуулаад яах юм бэ, ирэх жил хэдүүлээ тэрийгээ энэ 2 төв дээр хуваагаад 11, 11-ээр нь тавьчихмаар байна ТНБД аа. Энэ яг чухал тулгамдаад байгаа асуудал байхгүй юу. Тэр 5 тэрбумыг юунд зарцуулах юм, хэдэн реклам, контент хийгээд л, эм тариа авбал аваад л тэгээд л дуусчихна шүү дээ, хайран юм. Тэрний оронд энэ 2 барилгаа эхлүүлчихье. Манай энэ СЭМҮТ дээр тэр нэг донтолтоос сэргийлэх нэг тасаг эмчилгээ эмчилж байгаа, тэр үр дүн маш муутай байгаа. Тэгэхээр бид бие даасан төвтэй болох зайлшгүй шаардлага байгаа учраас энэ саналыг би харин гаргаж байна. Хууль зүйн яам энийг нэг тэмдэглэж аваад, дараа дараагийн асуудлууд дээрээ хандаарай гээд хэлье. Тэгээд би ганц л асуулт асуусан, тэр хариултаа л авчихъя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье, Сангийн яам хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам, Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ. Баярбаатар гишүүний асуултад хариулъя. ШЕЗ-өөс тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, мөн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж зэрэг яг хуулиар иргэнд олгодог энэ зардлуудыг төсвийн тодотголоор бууруулаагүй. Бид энэ удаагийн тодотголоор томилолт, тээвэр, шатахуун болон бусад энэ хэмнэлт хийх боломжтой зардлуудыг бүх салбараас яг ижил зарчим барьж бууруулсан. Энэ бууруулж байгаа арга хэмжээнд ямар нэгэн хуулиар биш, зүгээр байгууллагаас олгодог ийм тэтгэмжүүд болон урамшууллууд энд орно. Энэ зарчмын хүрээнд ШЕЗ-өөс 110 сая төгрөг хасагдсан байгаа. Тэгэхдээ энэ нь би дахиад хэлье, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж биш юм.

Л.Мөнхбаатар: Баярбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Баярбаатар: Монголбанк яг хариулаад, сая протоколд үлдээлээ шүү, ШЕЗ-ийн дарга энд сууж байна. Энэ дээр бид нарт тэр тараагдсан материал дээр 3 дээр нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 1 тэрбум 636 сая төгрөгөөр гэж байгаа шүү, энэ дээр байж байна. Тэгэхээр та сая хариулчихсан, таны хариулт протоколд үлдсэн. Тэгэхээр ямар нэгэн байдлаар 36 сарын тэтгэмж, энэ юм бол танагдахгүй юм байна, 110 сая төгрөгийн л асуудал байгаа юм байна гэдгийг энэ дээр ингээд хоёулаа Байнгын хороон дээр эцэслээд хагалчихъя, тэгэх үү, баярлалаа.

Л.Мөнхбаатар: УИХ-ын гишүүн Оюунсайханы Алтангэрэл асуултаа асууя.

О.Алтангэрэл: Эхний асуулт Монголбанкнаас, тэр танайхыг төлөөлж УИХ дээр ирсэн хэн билээ, тэр хариулж чадахгүй байна лээ, Энхтайван билүү. Та хэд чинь ер нь ингээд асуудал ярьж байхад Монголбанкнаас нэг тийм ач холбогдол өгөхгүй, тэр Ерөнхийлөгч нь, та ч би буруу ойлгоогүй бол 2 дугаар хүн нь байх, ирж хариулахгүй ингээд. Тэгээд тэр ирсэн хүнээс чинь асуухаар мэдэхгүй, нэг би маш энгийн асуулт асуугаад байгаа. Төв банкны тухай хууль дээр чинь Монголбанкны үндсэн зорилт төгрөгийн тогтвортой байдлыг хангана гээд тэр 4 дүгээр зүйл дээр чинь биччихсэн байгаа. Инфляц өсөөд байна гэж байгаа юм, өсөж байгаа, өнөөдөр 13 хувь гэж яриад байгаа боловч, яг амьдрал дээр наадах чинь хамаагүй их байгаа, бид бүгдээрээ мэдэж байгаа. Ингээд нэг өрөө тасалгаанд шигдээд суудаггүй, хөдөө гадаа явдаг, ард түмний амьдрал ахуйтай танилцдаг хэн ч хэлнэ наадах чинь хэтэрхий өндөр байгаа. Яах вэ, тэрийг дарлаа гэж бодъё, тэгвэл ер нь инфляц өсөж байгааг бид макро эдийн засгийн түвшинд зөвхөн энэ төсвийн бодлогоор дамжуулж, бүх хариуцлагыг энэ Засгийн газарт, төсөвт өгч ингээд яваад байх юм уу? Инфляц дээр тэр нэг бодлогын хүү өсгөлөө гэдгээс өөрөөр та хэд ер нь ямар нэг арга хэмжээ авахгүй юм уу? Инфляц өссөнд та нараас хэн хариуцлага хүлээх юм, ингээд өсөөд байвал хэн нь хариуцлага яаж, хүлээх юм бэ гэдэг маш тодорхой нэг асуулт байгаа шүү. Худлаа үнэн онол ном ярилгүй, элдэв нэр томъёогоор толгой эргүүлэлгүй энэ дээр яг тодорхой хариулт хүсэж байна танаас.

2-т нь, энэ Прокуророос асуулт байгаа юм. Миний ойлгож байгаагаар өнгөрсөн жилийн төсөв батлаад, одоо бол прокурорын байгууллага үндсэндээ тэр нэг жирэмсний амралтаа авсан, өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийнхээ тэр орон гарснаар нь цалин хөлсөө тавиад ингээд нэг юм арайхийж явж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь ямар хэмжээний дутагдал байна вэ, прокурорт? Үндсэн хуульд заасан чиг үүрэг бүхий институц шүү дээ. Тэгээд Прокурор нэг энэ ШЕЗ, ХЭҮК асуудлаа ярьж байгаа шиг Прокурор нэг асуудал яриадхаач.

3 дугаарт нь, ХЗДХЯ-наас асууя. Уг нь сайдыг нь байвал асуумаар байна. Ер нь энэ Даваагийн Цогтбаатар гишүүний хэлж байгаа үнэн шүү. Өнөөдөр ажил төрөл давхцаж байгаа юм байна, тэгэхдээ цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө, төсвийн ерөнхийлөн захирагчид нь өөрсдөө ирж энэ ХЗБХ-ныхоо хуралд оролцох ёстой шүү. Энэ ХЗБХ-ны гишүүд ямагт энэ хуулийн байгууллагуудын төсвийг нэмэгдүүлбэ, хасуулчихгүй юм сан, ахуйн нөхцөлийг нь сайжруулъя гэж явдаг шүү ер нь. Тийм учраас ер нь хүндэтгэлтэй оролцох ёстой шүү.

Би Хууль зүйн яамнаас асуух гэж байгаа асуулт, сая манай Баярбаатар гишүүн маш буруу ярьж байна, тэр архины сангийн мөнгийг шүүх шинжилгээний байгууллагад зарцуулъя гээд. Шүүх шинжилгээний байгууллагад орчин үеийн барилга хэрэгтэй байгаа нь үнэн, хэрэгцээ байгаа нь үнэн, тэгэхдээ энэ чинь хуулиараа юунд зориулах вэ гэдэг нь заачихсан мөнгө. Энэ мөнгийг төсөв ороод ирэхээр 5 тэрбум гээд тавьсан юм байна. Аль болохоор бүхэл дүнгээр нь аваад, энэ Мааньтын албадан эмчилгээгээ ядаж сайжруулчихъя, энэ мансууруулах бодист ороод живээд байгаа залуу үеэ эмчлэх, илаарьшуулах, сургалт явуулах энэ том төв барьчихъя гэдэг дээр саналаа оруулж ингэж ажиллана. Тэгэхээр энэ дээр ер нь энэ архины сан дээр яг ХЗДХЯ дээр яг тодорхой ийм юм хийчих юм сан гэсэн зорилго байна уу, төлөвлөж байгаа юм байна уу? Одоо энэ төлөвлөчихсөн байгаа 5 тэрбумыг нь юунд зарцуулах гээд байна, тэр сангийн үйл ажиллагаа маань ер нь

хэвийн явагдаж байна уу, хурал цуглаанаа хийж байна уу, тавигдсан төсвөөрөө юу хийж байна вэ гэсэн ийм яг тодорхой асуултуудад энэ 3 субъектээс хариулт авна.

Л.Мөнхбаатар: Гишүүний асуултад хариулъя. 3 номерын микрофон, Монголбанк хариулъя, дараа нь Прокурор бэлдэж байгаарай, тэгээд Хууль зүйн яам.

Э.Анар: Гишүүний асуултад хариулъя, Монголбанк Анар. 7 дугаар сарын инфляцын байдлаар 13 хувь, 8 сарын өчигдөр гарсан инфляцын тоогоор 12.5 хувь болж, махны инфляц ер нь 0.5 хувиар буурч ийм үзүүлэлттэй байна. Мэдээж инфляц нь өндөр байгаа нь яг нийлүүлэлтийн гаралтай гэх юм уу, яг ганц хоёрхон бүтээгдэхүүн дээр ер нь бараг 6, 7 хувийн инфляц ногдчихсон байгаа, тэр нь мэдээж мах, мөн дээрээс нь импортын буюу шатахуун дээр инфляцууд ерөнхийдөө ийм өндөр байгаад байна. Төв банкны зүгээс яг инфляцтай тэмцэх, инфляцын эсрэг ер нь яг ганц авч хэрэгжүүлэх арга хэмжээ мэдээж мөнгөний бодлого, хүүгээрээ л ер нь гол нөлөөлж, энэ эдийн засагт байгаа инфляцыг өдөөж байгаа төгрөгийг татах энэ боломж, бололцоо нь ганц л юун дээр, мөнгөний бодлогын энэ хэрэгсэл нь бол ганц л энэ дээр байгаад байгаа. Тэгэхээр зэрэг яг өнөөдрийн байдлаар Төв банк бодлогын хүүг 12.5 болгосон. Ирэх долоо хоногт Мөнгөний бодлогын хороо хуралдана, тэгэхээр яг өнөөгийн нөхцөл байдалтай хамааруулж ер нь бодлогын хүүг илүү чангаруулах уу, яах вэ гэдгийг тухайн хурлаар шийдэгдэх байх.

Өнгөрсөн 8 сард болсон ээлжит бус хуралдаанаар мэдээж энэ инфляц өндөр байгаа, өсөж байгаа энэ дүр зурагтай тэмцэхээр яалт ч үгүй ээлжит бус хуралдаанаар 0.5 хувиар инфляцыг хөдөлгөхөөс өөр арга байгаагүй. Тэгэхээр бид нарын хувьд яг энэ инфляцтай тэмцэх хамгийн байж болох ганц хувилбар бол мэдээж энэ мөнгөний бодлогын хүү дээр, дээрээс нь яах вэ, заавал байлгах нөөц, банкин дээр байгаа, зах зээл рүү гарах заавал байлгах нөөц гэж байгаа. Тэгэхдээ илүү бид хамгийн түрүүнд авах арга хэмжээ мөнгөний бодлогын энэ хүүтэй хүүгийн, мөнгөний бодлогын, бодлогын хүүгээрээ л ер нь хамгийн голчилж ингэж явж байгаа. Төсөвтэй холбоотой, мэдээж төсвийн тодотголтой холбоотой би түрүүн дурдсан. Оны эцэс, 4 дүгээр улирал гэхэд бид нарын судалгаа, шинжилгээгээр үзэхэд 0.5-аас 0.7 хувийн нэгжээр инфляцад нь дарамт учруулах болов уу, өсөх болов уу гэсэн ийм л хүлээлттэй байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Прокурорын байгууллагын төлөөлөл хариулъя. 6 номерын микрофон дээр суучих, дараа нь ХЗДХЯ хариулъя. Нэр, албан тушаалаа хэлээд гишүүний асуултад хариулаарай.

Д.Чулуунбат: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя, УЕПГ Чулуунбат. Үнэхээр прокурорын байгууллагын цалин дутуу байгаа, хүүхэд асрах чөлөөтэй болон өндөр насны тэтгэвэрт гарсан прокуроруудын цалинг хэмнэж, өнөөдрийн байдлаар прокурорын ажилтны цалинг тавьж байгаа. Өнөөдрийн байдлаар, 2026 оны 9 сарын байдлаар шинээр ганц ч прокурор томилогдоогүй байгаа. Томилох юм бол бид нарын цалингийн сан хүрэхгүй байгаа. Учир шалтгаан нь гэвэл прокурорын цалинг бүрэн гүйцэт олгоогүй, 26 оны төсөв батлахдаа. Тэгээд бид Сангийн яамныхантайгаа зөвшилцөөд, 2027 онд бид бүрэн орон тоогоор ажиллахгүй бол прокурорын ажлын ачаалал нэмэгдэж, өөрөөр хэлбэл, нэг төрийн албан хаагчид ногдох ажлын ачаалал нэмэгдсэнээр төрийн албан хаагч халшрах нөхцөл байдал үүсээд байгаа учраас бид бүрэн орон тоогоор цалингаа батлуулъя гэж Сангийн яамтай зөвшилцсөний хүрээнд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Чулуунбат дарга гүйцээгээд хариулчихъя.

Д.Чулуунбат: 2027 онд үндсэн бүтэц, орон тоогоороо цалингаа, саналаа хүргүүлсэн. Энэ саналтай холбогдуулаад манай 27 оны төсөв 20 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа гэдгийг гишүүдэд дуулгая.

Л.Мөнхбаатар: 5 номерын микрофон, ХЗДХЯ хариулъя.

Б.Батбямба: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу яг энэ санд төвлөрч байгаа хөрөнгийг тодорхой зүйлүүдэд зарцуулах ийм хуулийн заалттай байгаа. Бид хэд Сангийн яамтай удаа дараа энэ архины санг нээлгэх асуудлаар ХЗДХ-ийн сайд болон Сангийн сайд нар энэ асуудлаар нэлээн ярилцаж байгаа. Засгийн газрын тусгай сангийн асуудал жоохон хүндрэлтэй, нийтэд нь авч үзэхээр яригдаж байгаа ийм зүйлүүд Сангийн яамныхан хариу мэдээлэл өгч байгаа.

Тэгэхдээ бид 26 оны төсвийн тодотгол дээр ч саналаа өгсөн, энэ жил мөнгө тавигдаагүй, ирэх жилийн төсөв дээр 5 тэрбум төгрөг тавигдаж байгаа юм байна. Бид хуулийн дагуу нийт, эхний ээлжид нэн яаралтай хэрэгжүүлэх 13 тэрбум төгрөгийн төсөв, саналаа хүргүүлсэн байгаа. Архины сангийн хууль дээр ажлын албатай байх ёстой, одоогийн байдлаар ажлын алба нь байгуулагдаагүй, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын алба давхар хариуцаад явж байгаа. Тодорхой ажлууд хийгдэнэ гэдэг маань хуулийн дагуу сургалт, нөлөөллийн арга хэмжээ байна, эмчилгээний асуудлууд байна, дээрээс нь энэ хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хууль энэ намрын чуулганаар.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя, 5 номерын микрофоныг өгчих.

Б.Батбямба: Энийг дагалдаж Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл явж байгаа. Энэ дээрээ болохоороо зөвхөн энэ архидан согтуурахтай тэмцэх сангийн, архины сангийн энэ хөрөнгийг зөвхөн архины эмчилгээтэй биш, бас энэ мансууруулах бодистой холбоотой эмчилгээний зүйлүүдэд зарцуулж болохоор ийм хуулийн зохицуулалт хийж саналаа хүргүүлсэн, ингээд хэлэлцэхээр явж байгаа. Ер нь энэ 13 тэрбум төгрөгтэй холбоотой нийт ажлын дэлгэрэнгүй жагсаалтыг ХЗБХ-ны гишүүдэд өнөөдөр би хүргүүлж өгье, дэлгэрэнгүйгээр нь.

Л.Мөнхбаатар: Алтангэрэл гишүүн тодруулж асууя.

О.Алтангэрэл: Энэ Монголбанкнаас би асуухад яагаад хариуцлагын асуудал яриад байгаа юм бэ гэхээр, энэ инфляц байж л байдаг юм, ингээд л явдаг юм гэж бид ерөөсөө бодож болохгүй болчихоод байгаа юм. Тэгээд та бүхэнд ер нь Монголбанк болон Засгийн газрын хоорондын харилцааг хуулиар зохицуулчихсан байгаа. Тэгэхээр ер нь энэ бодвол ажил төрлөө анзаарч байна, Монгол Улсад төгрөгийн байдал ямар байна, одоо та хэд хараад сууж байдаг байлгүй дээ. Нөгөө нэг олон банк бусуудынхаа хөрөнгө мөнгийг өсөж байна уу гэдгийг харахаас гадна, ядаж энэ нэг ажил руугаа хараад яаж байна, ийж байна гээд ард түмний амьдралд санаа зовдог байлгүй дээ, эрх биш та хэд. Тэгэхээр ер нь энэ Засгийн газраас явуулж байгаа бусад төрлийн бодлого инфляцад нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн талаар зөвлөмж, санал, энэ зүйлүүдээ мэргэжлийн хүмүүсийн хувьд ер нь

илэрхийлдэг юм уу, ийм боломж, бололцоо байдаг юм уу? Энэ саналаа ер нь Засгийн газарт хүргүүлдэг юм уу, байр сууриа илэрхийлж ажилладаг юм уу гэсэн нэг ийм асуулт байна.

Л.Мөнхбаатар: Хариулъя, 3 номер уу?

Э.Анар: Гишүүний асуултад хариулъя. Мэдээж Төв банк, Засгийн газар хоорондын харилцааг хуулиар зохицуулсан байдаг, гишүүний хэлж байгаа үнэн. Тэгэхээр зэрэг энэ хүрээнд мэдээж ирэх жилүүдэд барьж байгаа тухайн Засгийн газраас өргөн барьж байгаа, мэдүүлж байгаа төсөв, мөнгөний бодлого нь мөнгөний утгатай ер нь хэр уялдах юм, мөнгөний бодлого талаасаа ер нь ямархуу байр суурьтай байх юм энэ талаар Засгийн газарт Монголбанкнаас тодорхой хэмжээний, мэдээж нөгөө нэг хуулиар энэ хоорондын харьцааг зохицуулчихсан байдаг учраас зөвлөмж маягаар ерөнхийдөө зөвлөмжүүдийг хүргүүлдэг, мэдээллүүдийг хүргүүлдэг. Мэдээж Засгийн газар дээр тооцоо хийж байгаа тооцоолол, Төв банкин дээр тооцоо хийж байгаа тооцоолол зарим тохиолдолд зөрөх асуудлууд байдаг. Тэгэхээр зэрэг мэдээж тус тусын өөр өөрсдийн тооцоолол юман дээрээ суурилж, ирэх жилийн төсөв, тэгээд мөнгөний бодлогыг мэдээж тооцоолоод явж байгаа. Тэгэхээр энэ тал дээр Төв банкнаас Засгийн газарт.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Нэг даргын хүүхэд томилчихсон чинь одоо бүр гишүүддээ загнуулдаг ажилтай болох гэж байгаа юм шиг байна. Би Анар Ерөнхийлөгчийн хобби руу ороогүй, хувь хүнийг чинь хүндэлж байна. Ерөнхийлөгч өө, та хоббигоо хөөгөөд морио уяад, сагсаа тоглоод явж бай. Энэ чинь инфляцын асуудал яригдаад байна, төгрөгийн ханш унаад байна, тэрийг яриад байна. Тэрнээс та бид хоёрын хобби ёстой 33 дугаар асуудал. Цаг наргүй ажиллаж байх ёстой газар чинь Монголбанк байхгүй юу даа. Тэгээд танай намын, үгүй ээ танай намын ч гэж дээ, нөгөө улаан намынхан чааваас даргынхаа төлөө үхэх гэж байна шүү дээ нэг хүүхдийг нь томилчихсон, жоохон шүүмжилчихсэн чинь. Дахиад хэлье, таны хобби энэ Монгол Улсад түй ч хамаагүй. Эхлээд та нар Монголбанк ямар бүрэлдэхүүнээр яаж ажиллаад инфляцыг яаж бууруулах юм бэ? Мөнгөний бодлого гээд нэг ийм, яах вэ, мөнгөний бодлого нэг ажил чинь мөн, нэг хэрэгсэл чинь мөн. Өөр яаж ажлын байрыг хангах юм, банкнуудтайгаа яаж хамтарч ажиллах юм ийм илүү дэлгэрэнгүй юм ярьж байгаа болохоос инфляц гэдэг үгийг одоо энд сууж байгаа бүх хүн цээжилчихсэн, нэмэгдэх юм байна. Та нар хариуцлага хүлээхгүй юм байна, төгрөг угаасаа унах юм байна, тэгээд бид та нарыг үе удмаар нь ингээд томилж өгөөд, давраагаад явж байх юм байна. Ийм л хөлдүү юм яриад байна шүү дээ, бүгдээрээ нийлж байгаад. Тэгээд би энэ ХЗБХ-ны даргыг эхнээс нь жоохон зүгээр зарчимтай байгаасай л гэж, шинэ даргад анхааруулах гэж түрүүний горимын саналыг гаргасан юм.

Үндсэн асуултдаа оръё. Хууль зүйн яамнаас яг хэдэн хүн танай салбарт ажиллаад байгаа юм, дундаж цалин хэд байгаа юм, 2020 онд хэд байсан юм, одоо хэд байгаа юм, тодотголын дараа хэд болох юм? Энэ дээр яг тодорхой хариулт байвал сайн байна.

АТГ-ын ажилтан ирчихсэн учраас олзуурхаад асууя даа. Хэдэн онд ажилд орсон бэ та, хэдэн төгрөгийн цалинтай байсан, одоо тодотголын дараа цалин чинь хэд болох гэж байгаа вэ? Нууц байж магадгүй, тэгэхдээ нэг ойролцоо дүнгээр хэлж өгөөч, энийг би дараад нь тайлбартайгаа ярья.

Тэгээд цагдаагаас уг нь хүмүүс ирчихсэн бол цагдаагийн даргаас нь ялангуяа асууя гэж бодоод байсан юм, одоо хариулах хүн ирчихсэн байгаа байх. Энэ Замын цагдаагийнхан ажилдаа жоохон хариуцлагатай хандмаар байна. Хот хооронд явж байгаа энэ тээврийн хэрэгслүүдийн стандарт бус цагаан гэрлээс болж маш олон осол аваар гарч байна. Эрдэнэт хүний амь нас эрсдэж байна, эд хөрөнгө үгүй болж байна, цаг хөрөнгөөрөө хохирч байна. Дээрээс нь нөгөө овор хэмжээ хэтэрсэн энэ нөгөө бараг байшинг чинь Улаанбаатарт бэлдчихээд нэг машин дээр зөөвөрлөөд аваад явдаг болчихлоо шүү дээ. Толинд нь юу ч харагдахгүй, өөдөөс ирж байгаа машин харагдахгүй, энэ хязгаарлалтуудыг Замын цагдаа нар орох, гарах пост дээрээ ч юм уу, энэ мөрдүүлж ажиллах хэрэгтэй байна. Энийг ярилцмаар байна.

2 дугаарт нь, Лицензийн төв гэж нэг газар хуучин нэрээр, одоо юу ямар нэртэй болсон юм мэдэхгүй байна, жолооч биш ер нь алуурчин бэлтгээд байна. Ямар ч самбаачлах ур чадвар, жолоодох ур чадвар байхгүй, тэгээд эд нар дээр чинь болоод энэ нийслэлд гарч байгаа түгжрэлийн асуудал, үргэлжлүүлээд хот, хөдөө орон нутгийн зам дээр гарч байгаа аваар ослын асуудлууд яригдаад байна. Энэ Лицензийн төвийн дарга хэр удсан хүн байдаг вэ? Жолооны курсүүдтэйгээ яаж хамтарч ажилладаг вэ, яавал ч ингээд нөгөө ур чадвартай, мэргэжлийн жолооч бэлдэх вэ? Жишээлэхэд, манай аав бүр 2 жилийн жолооны курст сууж байж нэг юм жолооч болдог байсан шүү дээ. Одоо ерөөсөө манай нөгөө Приус, Аккуа, Ланд ч юм уу унахад амархан, автомат болсон, хэн дуртай нь жолооны хүрд мушгиад давхидаг болсон. Хэн дуртайнхаа амь насыг бүрэлгэж байна, хэн дуртайнхаа эд хөрөнгийг сүйтгэж байна. Энэ дээр жоохон хариуцлагатай байх талаас та бүгд сүүлийн жилүүдэд ямар ажил хийж байна гэдгийг асуух гэсэн юм?

Тэгээд бид зүгээр ер нь Лицензийн төв дээр үнэмлэх гаргаж байгаа явдал зүгээр жолооны үнэмлэх зардаг л болчихоод байна. Яавал тэр хариуцлагатай жолоочийг бэлдэх юм бэ, яавал ур чадвартай жолооч гарах юм бэ, яавал түгжрэл үүсгэхгүй байх юм бэ, яавал хүний амь нас, эд хөрөнгө эрсдэхгүй байх юм бэ гэдэг талаас нь боддог бодлого бид нарт дутагдаад байна гэж би хараад байгаа учраас ЦЕГ-аас удирдлагуудаас нь ирээч гэж хүсэлт тавьсан чинь сүүлдээ мэргэжилтнүүд ирээд байгаа учраас л даргад анхааруулж хэлээд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Цогтбаатар гишүүний асуултад хариулна. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон, ХЗДХЯ хариулъя, дараа нь АТГ-ын төлөөлөл хариулна, дараа нь цагдаагийн байгууллага бэлтгэж байгаарай.

Б.Батбямба: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Манай салбарт нийт 27452 орон тоотой албан хаагчид ажиллаж байгаа. Энэ удаагийн төсвийн тодотголоор нийтдээ 1 тэрбум 670 сая төгрөгийн урсгал зардал нэмэгдэж орж ирж байгаа, цалингийн зардал дээр. Энэ болохоор саяын ярьсан төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 11 сараас 50 хувь нэмэхтэй холбоотой ийм нөхцөл байдалтай байна.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариул, өөр асуултууд тэмдэглэж авсан биз дээ. Цалингийн зөрүү гэж л асуугаад байгаа юм байна. Цогтбаатар гишүүн сая их тодорхой асуултууд асуугаад байна шүү дээ, тэрэнд нь гүйцээгээд хариулчих. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

Б.Батбямба: 26 онд манай салбарын алба хаагчдын цалингийн нэмэгдэл саяын төрийн үйлчилгээний албан хаагч дээр л орж байгаа. Бид 27 оны харин төсвийн тодотгол дээрээ нийт салбарын алба хаагчдын цалингийн хэмжээг, төрийн захиргааны алба хаагчдын цалингийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэхээр Сангийн яамтай харилцан тооцоогоо хийсний үндсэн дээр оруулж, төсвийн тодотголд тусгаж, 27 оны төсвийн төсөлд тусгаж оруулж байгаа. Дээрээс нь цагдаагийн болон бусад төрийн тусгай албан хаагчид, хууль сахиулагчдын өдрийн хоолны зардлыг нэмэгдүүлэх тал дээр саналаа хүргүүлсэн, төсвийн төсөлд тодорхой хэмжээгээр тусаж байгаа. Дээрээс нь нэмэгдээд Төрийн тусгай албан хаагчдын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх талаар төсвийн орон зайг бид ярилцаж, тодорхой саналуудыг тусгуулаад явж байгаа гэдгийг хэлье та бүхэнд.

Л.Мөнхбаатар: АТГ-аас төлөөлөл 6 номер дээр оччих. АТГ-ын удирдлагууд гадаадад томилолтоор ажиллаж байгаа, Солонгост хүний эрхийн комиссын чиглэлээр тэнд ажиллаж байгаа юм байна. Төлөөлөөд хэлтсийн дарга нь ирсэн, мэргэжилтэн биш байх тийм ээ? Хэлтсийн дарга, чи өөрийгөө танилцуулаад яагаарай. АТГ-ын хэлтсийн дарга Аззаяа асуултад нь хариулъя, 6 номерын микрофоныг өгчихье, тэгээд дараа нь цагдаагийн байгууллага.

Г.Аззаяа: АТГ, эрхэлсэн комиссар Аззаяа. Тамгын дарга өвчтэй байгаа, тэгээд дэд дарга гадаад томилолттой явж байгаа, тэгээд орлож ирсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Тамгын газрын, АТГ-ын Тамгын газрын энэ Маралмаа гээд ажилчдаас асуугаад байгаа юм уу та, нэр зааж асуугаад байгаа юм байна, асуултад хариул. Их Хурлын гишүүд асуулт асууж байна.

Г.Аззаяа: Надаас асууж байна уу?

Л.Мөнхбаатар: Биш ээ, Маралмаа гэсэн тэр хүнээс асуугаад байгаа юм байна.

Ш.Маралмаа: АТГ Маралмаа. Манай тодотголд бол ямар нэгэн цалин дээр зөрүү гараагүй байгаа, тодотголоосоо шууд ярьчих уу.

Л.Мөнхбаатар: Төсвийн тодотголоор өөрчлөлт орж байгаа юм уу л гэсэн агуулга хэлээд байгаа юм байна, түүнийгээ тодорхой хариулчих.

Ш.Маралмаа: Тодотголоор манай цалинд ямар нэг өөрчлөлт ороогүй байгаа.

Л.Мөнхбаатар: Болно. Цагдаагийн байгууллагын төлөөлөл асуултад хариулъя. ЦЕГ-ын дарга гадаадад томилолттой явж байгаа юм байна. Гэхдээ энэ тэргүүн дэд дарга чинь яагаад ирээгүй вэ? Энэ зарчмын асуудал шүү, нөхөд өө. Ер нь дараагийн хурлууд дээр төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн захирагчид хүндэтгэн үзэх шалтгаанаас өөр шалтгаанаар ирэхгүй байгаа тохиолдолд уг асуудлыг Байнгын хорооны гишүүдийн саналаар асуудлыг нь хойшлуулаад явна шүү, хэлэлцүүлэхгүй ийм зарчим барина гэдгийг та бүгдэд анхааруулан хэлье. ХЗДХЯ өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагаа бүрэн хариуцна. Байнгын хорооны дэргэдэх асуудлуудыг манай Байнгын хорооны албан хаагчид, ажилтнууд холбогдож бүрэн оролцуулна гэдгийг энд хэлье. ЦЕГ-аас ирсэн төлөөлөл өөрийгөө танилцуулаад асуултад хариулъя.

Д.Батчулуун: Хурандаа Батчулуун, ЦЕГ-ын Санхүү, ар талын албаны дарга. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ерөнхий газрын дарга гадаад томилолттой яваа. Юун дээр, нийтдээ замын цагдаагийн үйл ажиллагааны талаар асууж байна. Өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллагад замын цагдаагийн чиглэлээр мянга гаруй алба хаагчид үүрэг гүйцэтгэж байна. Үүний 600 гаруй нь Улаанбаатар хотод, 300 нь орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа. Улсын хэмжээнд хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, журмын талаар зохион байгуулж байгаа ажлынх нь талаар мэргэжлийн нэгжүүдээс нь танд дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлье.

Дараа нь Лицензийн төвийн талаар тодруулж асууж байна. Лицензийн төв нь өнөөдөр Зөвшөөрөл, үйлчилгээний төв нэртэй үйл ажиллагаа явуулдаг, БГД-ийн нутаг дэвсгэрт байдаг, 50 гаруй хүнтэй. Мэргэжлийн жолооч бэлтгэх үйл ажиллагаа нь Хөдөлмөрийн сайд, Боловсролын сайд нарын хамтран гаргасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх гэдэг журмын дагуу жолооч бэлтгэж, шалгалт авах журмаа хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Хууль зүйн яамнаас ч гэсэн би уг нь тодорхой асуусан юм, 20 онд танай дундаж цалин хэд байсан, одоо хэд болчихоод байгаа юм бэ гээд. Тэгээд АТГ-ын ажилтан ирсэн болохоор нь олзуурхаж асуусан юм. 20 онд цалингийн зардалд 2.6 их наяд төгрөг Монгол Улсад зарцуулдаг байсан, одоо энэ Засгийн газрын өргөн барьсан тогтоолын тодотголын дараа 7.7 их наяд болох гээд байгаа байхгүй юу. Ер нь 2-оос 3 дахин нэмэгдээд байгаа юм. Ингээд цагдаа ч юм уу, энэ онцгой ч юм уу, онцгой нөхцөлд энэ прокурорынхон ч юм уу ажиллаж байгаа, ажлын ачаалалтай байгаа улсуудын цалин их байгаасай гэж хүсэж байна. Наадуул чинь тангараг өргөсөн гээд чааваас шөнийн хэдэн цагт ч хамаагүй дуудагдаад л явдаг албан тушаалтнууд шүү дээ. Тэгэхээр цалин нь их байгаасай гэж бодож байгаа. Гэхдээ яг байгаа онож байна уу гэдгийг л бид ойлгохгүй байна. 2.6-аас 7.7 болтлоо нэмэгдчихээд ажилтан өмнө нь 2 сая төгрөгийн цалин авдаг байсан бол одоо 2 сая 200-г авч байгаа бол энэ чинь байгаа онохгүй байгаагийн шинж. Тэгэхээр бид байгаа онодог цалин бодож олгохын төлөө л энийг асуугаад байгаа юм гэдгийг зөвөөр ойлгоосой. Цагдаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулж хариулах уу? ХЗДХЯ хариулъя, 5 номерын микрофон өгье.

Б.Батбямба: Манайх холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн албаны шатлалынхаа дагуу л цалингууд бодогдоод явж байгаа. Жишээ нь, төрийн захиргааны хамгийн өндөр албан хаагчид байгаа ТЗ-1, миний хувьд үндсэн цалин 2.9 сая төгрөг байгаа, тэгээд тэрнээс доошоо ингээд шатлалынхаа дагуу буураад явж байгаа. Төрийн үйлчилгээний албан хаагчид мөн ялгаа байхгүй, яг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн шатлалын дагуу цалингаа аваад явж байгаа. Ерөнхийдөө нийтлэг жишгээр Монгол Улсын хэмжээнд яг цалинг нь яг нарийвчлаад, жишээ нь ТҮ дээр тэдэн төгрөг гээд хэлэх боломжгүй байна. Энэ шатлалынхаа дагуу манай цалингийн хэмжээ тогтоогдсон байгаа. Жирийн, анх удаа албан тушаалд орж байгаа мэргэжилтний цалин 2.1 саяас эхэлж байгаа. Дээрээс нь сая би дутуу хариулсан байна, уучлаарай. Энэ жилийн цалингийн сан дээр нэмэгдэж дутагдалтай байгаа 1.2 тэрбум төгрөгийн зардлыг Сангийн яамнаас дэмжин төсвийн тодотголд тусгаж өгсөн байна, энийг сая би харлаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Байвал нэрсээ өгье. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Ерөнхийдөө нөгөө ХЗДХ-ийн салбарын, шүүх эрх мэдлийн салбарын хүмүүс орж ирлээ. Тэгээд энэ цалин хөлсний бодлогыг яг зарчим барьж жигдхэн авч явахгүй бол яг нэгийг нь хэт өсгөчихвөл нөгөө рүүгээ шилждэг, нөгөө байгууллага нь хэвийн үйл ажиллагаа алдагддаг, хүний нөөц талаасаа ийм үр дагаврууд гардаг юм. Энэ дээр манай ХЗДХЯ анхаарч хандаасай. Ялангуяа яах вэ, зүгээр хууль зүйн салбарын гол бүтээгдэхүүн буюу судалгаа л байгаа л даа. ТУ шинжлэх ухааны тэр салбаруудыг ерөөсөө битгий орхигдуулаач. Уг нь энэ дээр илүү их цалин өгч залуучуудыг татах ёстой л юм байгаа юм, тэгэхээр энэ ингээд зүйлүүд байхгүй байна.

Би нэг сонин кэйсийг ярьчихъя л даа. Сая Солонгост гарлаа шүү дээ, нэг Солонгосын хууль сахиулах албанд ажилладаг хүнийг баривчиллаа. Яасан бэ гэхээр, ажлынх нь энэ ачаалал гэдэг юм уу энэ зүйлүүдийг нь алдагдаад ачаалалтай байсан учраас ерөнхийдөө тухайн мэдээлэл гаргагчдаа юм уу, эсхүл мэдээлэлд дурдагдсан этгээдүүдтэй холбогдсон гэдэг үндэслэлүүдээр өргөдлүүдийг нь хаагаад явсан. Ингээд сая хүний эрүүл, аюулгүй байгаа гэдэг хүн нас барсан байдалтай олдоод, тэр хүний яаж ажилдаа хандаж байсан зүйл нь харагдаж байгаа байхгүй юу. Тэр хүний тайлбар нь хэлж байна лээ шүү дээ, маш их хэмжээний ачаалалтай ажилладаг, энэнээсээ болоод энэ стресс, ажлын хам шинжээсээ болоод ажилдаа ингэж хандаж байгаа гэж. Тэгэхээр энэ хууль сахиулах салбарын юмыг бид бодолцох ёстой юм. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрхийг хангаж орлого олдог салбар биш байхгүй юу. Тэгээд энийг ингээд зэрэгцүүлээд янз бүрийн байдлаар ингээд багасгаад, ихэсгээд, энэ их эмзэг салбар шүү гэдэг зүйлийг л хэлмээр байна. Тэгээд энэ дээр манай Сангийн яам ойлгож, хүлээж аваасай. Ер нь зүгээр яах вэ, улсын эдийн засгийн нөхцөл байдал тийм таагүй байгааг ойлгож байгаа, зарчмаар нь ерөнхийдөө хандаж байгааг ойлгож байгаа боловч ийм зүйлүүд ер нь гараад байна шүү гэдэг зүйл байна.

2 дугаарт, тэр архины сангийн асуудлыг шийдээч. Архины сангийн асуудлуудыг хууль дээр бүр тодорхой заачихсан байхгүй юу, энэ мансууруулах, дэлгэцийн дон, архины донтолтыг эмчилнэ гээд бүр хууль дээрээ бичээстэй байгаа Батбямба дарга. Миний үед энэ дээр бие даасан ажлын алба гаргахгүйгээр Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргаараа хавсруулаад, Хөдөлмөрийн хуулийнх нь дагуу хавсарч цалинг нь олгоод шийдээд явъя л гэж байгаа юм. Дараа жил тавхан тэрбум тавих юм байна, энэ 5 тэрбумаар чинь эмнэлэг барьж чадахгүй. Энэ юугаар эмнэлэг барих ёстой шүү, эмнэлгийн байршил тодорхой болчихсон, Дорнод, Баянхонгор, СХД ингээд явчихвал энэ олон айлуудыг нэг жоохон цэгцэлж өгнө, энэ чинь яг үнэндээ хэлэхэд, архины донтолтод орчихсон хүмүүсийг хаана аваачихыг нь мэдэхгүй, цагдаа аваачаад шүүхээр орууллаа, албадан эмчилгээгээр 3 сарын ялаа. Энэ чинь өөрөө сэтгэл зүйн асуудал бараг жил хагасын асуудал явдаг байхгүй юу. Ингэж байж хүн өөрөө эргээд илаарьшина, мансуурах бүр ялгаа байхгүй. Тэгэхээр ийм хэмжээний хэдүүлээ ингээд яваад байдаг, энэнээсээ болоод л нөгөө гэмт хэргийн гаралт чинь ихсэж байгаа, гэмт хэргийн хохирогч болоод өөрөө явдаг, сүүлдээ гэмт хэргийг гаргадаг, хулгай зэлгий, ер нь зүгээр амиа хорлолт гээд бүх юм чинь энэ дээрээ явж байгаа шүү дээ. Бид хэд энийг өвчтөн гэдэг утгаар нь ерөөсөө

харж чадахгүй төрийн бодлого байгаа, бүгд ярьдаг, бүгд уянгалдаг, тэгэхдээ шийдэж чадахгүй байсан.

Тэгэхээр энэ 22 тэрбумыг ер нь ирэх жилүүдээс нэг ойлголцоод, энэ ирэх жилийн төсөв хэлэлцэхэд, ажлын хэсэг гаргахад нэг Хууль зүйн яам маань өөрөө хичээгээд яваач. Тэгээд Баянхонгорт байдаг юм уу, Дорнодод ч байдаг юм уу, тэр нэг байршлын эмнэлгийг нь бариадах л даа. Тэгээд хэдүүлээ нэг үр дүн гаргаад, нэг архинаас ийм хүн гарлаа. Энэ хэцүү байдаг байхгүй юу. Улам лавшрах тусам нийгмийг, нөгөө тэр орчин, жижиг орчин аз жаргалгүй болдог. Тэгээд сүүлдээ ингээд нийгэм тэр чигээрээ ийм стресстэй, бухимдалтай, айдастай ийм болж байгаа, энийг анхаараач.

2 дугаарт, би яах вэ зүгээр зарчмын хувьд тодотголтой холбоотой биш боловч, Сангийн яам дээрээ сая уг нь Мэндсайхан сайд байсан бол ярилцъя гэж бодсон. Мэндсайхан сайд маань энэ асуудал дээр жоохон уян хатан ханддаг гэж би ойлгож байгаа. Ирэх жилүүдээр энэ болдог бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр шүүх эрх мэдлийн улсын хэмжээн дэх бүх барилгыг барьчихъя. Тэгээд энэ шүүх эрх мэдэл гээд бие даасан Үндсэн Хуулийн институциэ хэдүүлээ нэг хандчихъя. Энд яг өөд өөдөөсөө хараад, шүүхэд бие биеийнхээ эсрэг маргалдах гэж ярья л даа, энгийн үгээр мэтгэлцэх тийм боломж байхгүй.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Хэлэлцүүлэг өнөөдөр төсвийн тодотголын танилцуулга хийгдэж байгаа. Дараагийн буюу гурав дахь хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй санал гаргах болоод санал хураалтууд явагдана. Тийм учраас өнөөдөр Байнгын хорооны гишүүдийн хэлсэн үг, асуусан асуулт, хөндсөн сэдвүүдээр манай хэлэлцүүлэгт оролцож байгаа манай Ажлын хэсгийнхэн бэлтгэлээ сайн базаана шүү. Өнөөдөр хариултууд хангалтгүй байна гэж гишүүд үзэж байна. Тийм учраас дараагийн хэлэлцүүлэг дээр ажил хэрэгч байж, албан тушаалтнуудаа бүрэн оролцуулж, хэлэлцүүлэгт бүрэн бэлтгэлтэй ирэхийг та бүгдэд сануулан хэлье. Өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна. 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны танилцуулгыг Төсвийн байнгын хороонд УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

16.27 цаг

Ингээд хуралдаанд оролцсон гишүүдэд талархал илэрхийлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА